



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • I • № 15

Н.БАЯРТСАЙХАН:
**ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРТЭЭМЖТЭЙ
ӨСӨЛТИЙН ТУЛГУУР
НЬ САНХҮҮГИЙН
ХЭРЭГЛЭГЧ**

**ЭДИЙН ЗАСГИЙН
ТОГТВОРТОЙ
ӨСӨЛТИЙГ
"АРГАМЖИХ"
ХАРИУЦЛАГАТАЙ
ЦАГ ИРЭЭД БАЙНА**

**МОНГОЛБАНКНААС
2012-2016 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН
МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ЭДИЙН
ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН
НӨЛӨӨ**



ЭРДЭНЭСИЙН САНГААС: ГАРХИН ХЭЛБЭРТЭЙ АЛТАН ЭЭМЭГ /Хүннүгийн үе НТӨ III-НТ I зуун/



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛО



Эдийн засгийн нөхцөл байдлыг дүгнэх, санхүүгийн салбарт гарч буй өөрчлөлт, төрөөс хэрэгжүүлэх шаардлагатай бодлогуудыг хэлэлцсэн “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган” 2018.01.19-20-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулагдлаа. Монголбанкнаас санаачлан “Эрдэнэт” ХХК, Улаанбаатар төмөр зам ХНН-тэй хамтран зохион байгуулсан чуулга уулзалтад эдийн засгийн бодлого тодорхойлогч төрийн байгууллагууд, эрдэмтэн судлаач, баялаг бүтээгчдээс бүрдсэн 100 гаруй төлөөлөгчид оролцов.

Жил бүр оны эхэнд зохион байгуулагдахаар болж буй уг чуулганаар эдийн засгийн төлөв, тулгарах сорилтууд, түүнийг давахын тулд төрийн байгууллагууд бодлогоо уялдуулахад эрдэмтэн судлаач, баялаг бүтээгчдийн хамт хэлэлцүүлж, зөвлөмж гаргаж байх юм.



ГЫН АНХДУГААР ЧУУЛГАН



Анхдугаар чуулганаар тулгарч буй дөрвөн асуудлыг онцлон нээлттэй хэлэлцүүлсэн нь, өнгөрсөн жилүүдийн эдийн засгийн бодлогын хэрэгжилт, түүнээс авах сургамж, 2018 оны эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв, сорилтууд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, цахим мөнгө болон криптовалют зэрэг байв. Чуулганы үеэр нийт оролцогчид Монголын эдийн засагт нааштай үр дүн гарч эхэлж байгаа энэ үеийг ашиглан төрийн бодлогын алдааг засч, цаашид зөв, оновчтой бодлого хэрэгжүүлэх хөрс суурийг бүрдүүлэх явдал чухал байгаад санал нэгдэв.



Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

Банкуудад эрсдэлд суурилсан хяналт шалтгалт хийгддэг болно

ХУУДАС

5

Ярилцлага:

Н.Баяртсайхан: Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийн тулгуур нь санхүүгийн хэрэглэгч

ХУУДАС

7

Инфографик:

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэж юу вэ?

ХУУДАС

10

Нийтлэл:

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг "аргамжих" хариуцлагатай цаг ирээд байна

ХУУДАС

15

Монголбанкны Эрдэнэсийн сангаас:

Хүннүгийн үеийн алтан ээмэгнүүд

ХУУДАС

17

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас... /2018.01.25/

ХУУДАС

20

Монголбанк юу хийдэг вэ?

Валютын ханш гадаад валютын эрэлт нийлүүлэлтээс хамаардаг

ХУУДАС

27

Мөнгөн тэмдэгтийн түүх:

Өгөөдэй хааны үеийн мөнгөн зоос

ХУУДАС

30

Банкир:

Т.Батбаяр: Зээлийн хүү, ханшийг хүчээр тогтоох болчимгүй алхам байж болохгүй

ХУУДАС

31

Монголбанкны судалгаа:

Монголбанкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлсэн нөлөө

ХУУДАС

36

Дэлхийн эдийн засаг:

2006 оны Нобелийн шагнал-Инфляци болон Ажилгүйдлийн хамааралд хийсэн Эдмунд Фелпсийн нээлт

ХУУДАС

39

Санхүүгийн боловсрол:

Санхүүгийн боловсрол болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг

ХУУДАС

41

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аян 5 сарын хугацаатай хэрэгжинэ

Монголбанкны санаачилгаар “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах” 5 сарын аян 1 дүгээр сараас эхэллээ. Аяны хүрээнд Монголбанк, түүний орон нутаг дахь хэлтэс, салбар, банкууд, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын Ипотекийн Корпораци, Монголын Банкны холбоо, Хадгаламжийн Даатгалын Корпораци, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран санхүүгийн хэрэглэгчдэд мэдлэг, мэдээлэл олгох, Санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль боловсруулах, батлуулах зэрэг 5 чиглэлээр ажиллах юм. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар Дэлхийн бакнаас өгсөн зөвлөмжийн дагуу Монголбанк шат дараалсан ажлуудыг хийж байна. Үүний нэг нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд Төв банкны үйл ажиллагааны чиглэлд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг нэмж тусгаад байна.



“Мүүдиз” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В3 болгож дээшлүүлэв



Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний “Мүүдиз” агентлаг 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “Саа1”-ээс “В3” болгон дээшлүүлж, төлөвийг тогтвортой хэвээр үлдээв. Ийнхүү зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэхэд тус агентлаг дараах үндэслэлийг авч үзсэн байна. Тодруулбал, Монгол Улсын төлбөрийн чадвар, хөрвөх чадвар сайжирч, эдийн засгийн шинэчлэлийн бодлого амжилттай хэрэгжсэн тохиолдолд түүхий эдийн үнийн савалгаанаас хамаарах мэдрэмж тодорхой хэмжээгээр буурах төлөвтэй байна. Мөн 2017 оны эцэст Засгийн газрын өрийг дахин санхүүжүүлж, төсвийн алдагдлыг бууруулж, орлого нэмэгдсэнээр Монгол Улсын санхүүжилтийн хэрэгцээг бууруулж, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэх шинэчлэлийн бодлогуудыг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн эрсдэл буурахаар байгаа зэрэг нь нөлөөлжээ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан баталлаа

Улсын Их Хурлын 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Хууль шинэчлэгдсэнээр Монгол Улсын Төв банк -Монголбанкны эрх зүйн байдлыг Монголбанкны бие даасан, хараат бус байдал, шийдвэр гаргах үйл явцыг олон улсын бусад төв банкуудад тогтсон шилдэг туршлага, зарчимд шилжүүлэв. 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хууль хэрэгжиж эхэлснээр мөнгөний бодлого болон банкны хяналт шалгалтын шийдвэрийг хороогоор дамжуулан хэлэлцэн шийддэг болохын зэрэгцээ Монголбанкны зорилтод үл хамаарах төсвийн шинжтэй үйл ажиллагаа хязгаарлагдаж, Төв банк Засгийн газраас хараат бус байж, түүнтэй зөвхөн хуульд заасны дагуу харилцдаг байх зарчим хуулиар баталгаажиг байна.



Банкуудад эрсдэлд суурилсан хяналт шалтгалт хийгддэг болно

УИХ-ын чуулганы 2017.01.18-ны өдрийн хуралдаанаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, эцэслэн баталлаа. Уг хуулинд нэмэлт өөрчлөлт орсноор банкны төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн болон гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэв. Мөн төв банкнаас банкуудад тавих хяналт, шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрхтэй байхаар зохицуулав. Ингэснээр төв банкны хяналт, шалгалтын хүч нэмэгдэж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүргээ биелүүлэх нөхцөл, боломжийг нэмэгдүүллээ. Шинээр батлагдсан хууль 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



Монголбанкны Хяналтын зөвлөл хуралдав



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2018 оны 1 дүгээр сарын 15-нд болов. Тус хурлаар Монголбанкны гадаад валютын байршил, урт, богино хугацаатай хөрөнгө оруулалтын багцын байдал, валютын позиц, гадаад өр төлбөрийн асуудлын талаар Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Монголбанкны гадаад валютын улсын нөөцийн удирдлага, эрсдэлийн менежментийн талаар Эрсдэлийн удирдлагын албаны ахлах эдийн засагч Б.Ганзаяа, ахлах эдийн засагч Ч.Лхагвадулам нарын сонгол мэдээллийг хэлэлцэв. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Хяналтын зөвлөлийн гишүүн Л.Ариунаа мэдээлэл хийв. Хяналтын Зөвлөлийн хурлаас гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа Монгол Улсын өрийн үйлчилгээ 2022 он хүртэл жилээс жилд нэмэгдэх эрсдэлийг тооцож ажиллах, гадаад валютын нөөцийг тайлагнадаг олон улсын стандартыг мөрдөж ажиллахыг Монголбанкны холбогдох газруудад зөвлөв.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран дахин сайжруулна

Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-т эдийн засаг, санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн. Түүнчлэн Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн дагуу Олон Улсын Хадгаламжийн даатгагчдын холбооны “Хадгаламжийн даатгалын үр нөлөөтэй тогтолцооны үндсэн зарчим”-д нийцүүлэн хадгаламжийн даатгалын корпорацийн засаглал, сангийн эх үүсвэр, зарцуулалт, даатгалын хамрах хүрээ, хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох харилцааг боловсронгуй болгох зорилгоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж эхэллээ.



Н.БАЯРТСАЙХАН: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТИЙН ТУЛГУУР НЬ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ

Сүүлийн үед дэлхийн улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахыг чухалд үзэх боллоо. Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээс эхлээд, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, бизнесийн сайн арга барилыг мөрдүүлэх, маргааныг шийдвэрлэх зэрэг чиглэлээр хурдацтай дэвшилүүд бий болж байна. Энэ нь санхүүгийн хүртээмжийг дээшлүүлж, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн тулгуурыг бүрдүүлдэг байна. Монгол Улс ч олон улсын энэ чиг хандлагатай хөл нийлүүлэн алхахын тулд Төв банкин дээр ямар ямар ажил хийж байгаа талаар Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ярилцлаа.



Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг дээшлүүлэх нь Монголын санхүүгийн салбарт хийж буй нэг чухал шинэчлэл шүү дээ. Үүнийг яагаад хийх болсон бэ гэдэг асуултаар ярилцлагаа эхэлье.

-2012 онд Дэлхийн банк манай улсад Санхүүгийн боловсрол, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж буй байдлын судалгааг хийгээд “Хангалтгүй байна, сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтэд хүрээд хэд хэдэн зөвлөмж өгсөн байдаг. Үнэхээр ч хууль эрх зүйн орчноос эхлээд, тэдгээрийг хэрэгжүүлэх институцийн оновчтой зохион байгуулалт, үүссэн асуудлуудад цэгцтэй анализ, дүгнэлт хийхэд туслах мэдээллийн нэгдсэн сан гээд Монгол Улсад дутуу зүйл олон. Иргэд, хэрэглэгчдийн хувьд ч эрх ашиг нь ямар тохиолдолд зөрчигдөж байгааг, зөрчигдсөн тохиолдолд хэнд хандаж яаж шийдвэрлүүлэх вэ гэдэг талаарх мэдлэг хангалтгүй. Монголбанкны зүгээс энэ байдлыг сайжруулах зорилгоор санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр улс орнуудын шилдэг туршлагыг судлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, техник туслалцаа авах зэргээр нэлээд идэвхтэй ажиллаж байна. Сүүлийн жишээ гэхэд, бид Азийн Хөгжлийн Банктай хамтарч ажиллан, үндэсний хэмжээний болон олон улсын хурлуудыг 2017 онд мэргэжлийн хүрээнийхний дунд зохион байгуулсан. Мөн өнгөрсөн 7 хоногт УИХ-аар батлагдсан Төв банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар тодорхой заалт орсон нь томоохон дэвшил болсныг онцлох нь зүйтэй.

Ингэснээр Монголбанкинд санхүүгийн хэрэглэгч болон хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалахад суурилсан хяналт, шалгалтын эрх зүйн орчин бүрдэхэд нэг алхам ойртлоо гэж үзэж болно. Энэ сараас эхлээд Монголбанкнаас нийт иргэд, олон нийтэд хандсан “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” аяныг эхлүүлээд байна. Зөвхөн мэргэжилтнүүд төдийгүй, иргэд хэрэглэгчид өөрсдөө маш сайн ойлголттой байх нь чухал. Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн тулгуур нь өөрөө санхүүгийн хэрэглэгч юм.

Дэлхийн чиг хандлагыг харахад санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад онцгой анхаарал хандуулах болсны цаад ач холбогдол нь юу байж болох вэ?

-Санхүүгийн зах зээл маш олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн хэрэглэгчээс бүрддэг. Зохицуулагч байгууллагын зүгээс бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож буй санхүүгийн байгууллагуудыг хянах, үйл ажиллагааг нь найдвартай байлгах тогтолцоо, арга механизмыг нэлээд сайн хөгжүүлсэн. Тэгвэл сүүлийн үед эрэлт тал буюу хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь эцсийн дүндээ эдийн засгийн тогтвортой байдал, хүртээмжтэй өсөлтийн нэг түлхүүр болдгийг судалгаа харуулж байна. Иймд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах сайн тогтолцоог бүрдүүлэхэд улс орон бүр зорих боллоо. Тухайлбал, энэ сэдвээр Дэлхийн банкнаас гаргасан сүүлийн тайлангаас харахад, тайланд бүртгэгдсэн 120 гаруй улс орны дийлэнх олонх нь аль

нэг байдлаар анхаараад, холбогдох ажлуудыг хийж хэрэгжүүлээд эхэлжээ. 60 гаруй оронд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний стратеги хүртэл боловсруулаад хэрэгжүүлээд явж байна.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал, санхүүгийн байгууллагын бизнесийн арга барил, үүссэн маргааныг шийдвэрлэх 3 чиглэлээр түгээмэл хандаж байна. Эдгээр нь эдийн засгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

-Юуны өмнө, мэдээллийн ил тод байдлыг авч үзье. Технологийн дэвшил, санхүүгийн зах зээлийн хөгжилтэй зэрэгцээд өнөөдөр маш олон төрлийн бизнесийн модел, бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болсон байна. Зөвхөн нэг банкны хувьд аваад үзэхэд зээл эсвэл хадгаламжийн бүтээгдэхүүн нь дотроо нэлээд олон төрөл зүйлтэй. Дээр нь даатгал, хөрөнгийн зах зээл, банк бус санхүүгийн байгууллагууд, сүүлийн үед технологийн компаниуд хүртэл санхүүгийн үйлчилгээ санал болгоод эхэллээ. Ийм үед санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ сонгож буй хэрэглэгч ямар бүтээгдэхүүнийг, ямар нөхцөлтэй авах гэж байгаагаа тодорхой мэдэх боломжтой байх нь чухал. Учир нь үнэн зөв мэдээлэл дээр суурилсан шийдвэр л илүү оновчтой, хариуцлагатай байдаг шүү дээ. Энэ нь эргээд эдийн засагтаа ч эерэг нөлөөтэй. Санхүүгийн зах зээлд оролцож буй хүмүүсийн мөнгөтэй холбоотой шийдвэрүүд оновчтой байх тусмаа л эдийн засаг тогтвортой байна гэсэн үг. Ингэснээр мөнгөний бодлого ч илүү үр дүнтэй хэрэгжихэд тустай. Дараагийн нэг зүйл бол, хэрэв хэн нэгэн этгээд ямар нэгэн зүй бус, ёс зүйгүй эсвэл алдаатай буруу арга барилаар бизнес хийж байвал үүнийг таслан зогсоох нь зохицуулагчийн гол үүрэг.

Санхүүгийн систем маань өөрөө итгэл дээр тогтдог тул энэ нь маш чухал. Санхүүгийн ертөнц цахим хэлбэр лүү хурдтай шилжиж буй энэ үед мэдээллийн нууцлал, аюулгүй байдал ч чухал асуудлын нэг. Жишээ нь, хэрэглэгчийн утасны дугаараас эхлээд цалин орлого, өмч хөрөнгийн талаарх хувийн шинжтэй, зарим нь нууц байх учиртай мэдээллүүдийг банк хэр найдвартай хадгалж чадаж байна вэ гэдэг том асуулт юм. Мэдээж аливаа маргаан үүссэн тохиолдолд хэрхэн үр дүнтэй, хурдан шуурхай шийдвэрлэж байна вэ гэдэг зүйл яригдана. Энэ бүгдийг цогцоор нь агуулж буй санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоо нь эцсийн дүндээ хэрэглэгчид тустай байхаас гадна санхүүгийн байгууллагад итгэх итгэлийг дээшлүүлэх, санхүүгийн

үйлчилгээ тогтвортой байх, хүртээмжтэй байх нөхцөл болдог.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь санхүүгийн зах зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй байдалд эерэг нөлөөтэй байх нь ээ. Энэ нь эдийн засгийн өсөлт илүү олон хүнд хүртээмжтэй байхад хувь нэмэр оруулах бололцоотой юу?

-Том зургаараа эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг бий болгох нэг хүчин зүйл гэж ойлгож болно. Сүүлийн үед дэлхий дахинд эдийн засагчид, бодлого тодорхойлогчдын толгойн өвчин болсон нэг асуудал бол нийгмийн тэгш бус байдал юм. Даяарчлал хүчээ авч, олон улсын худалдаа асар ихээр тэлж, маш их хэмжээний баялаг, хөрөнгө бий болсон хэдий ч, баян, хоосны ялгаа нэмэгдлээ. Гэтэл үүн дээр нэмээд дэлхийг хамарсан томоохон эдийн засгийн хямрал тохиоход санхүүгийн хувьд хамгийн эмзэг бүлэг илүү хүчтэй өртөж, хямралын гол хохирогсод болсон. Баян, ядуугийн ялгаа ихэсч, тэгш бус байдал ийнхүү нэмэгдэх нь улс орны эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, улмаар тогтвортой хөгжил, цаашлаад нийгмийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд тэгш бус байдлыг бууруулахын тулд "эдийн засгийн өсөлт өөрөө тогтвортой бөгөөд олон хүнд хүртээмжтэй байх ёстой" гэдэг зүйл аль ч улсад чухал болж байна. Өсөлт савлагаа багатай, нийгмийн олон давхаргад үр өгөөжтэй байсан цагт л ядуурал буурна, нийгмийн тэгш бус байдал багасна. Ийм өсөлтийг бий болгоход санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал маш чухал байдаг. Иргэдэд санхүүгийн эрсдэлээ илүү оновчтой удирдах боломжийг дээшлүүлдэг болохоор тэр. Тэгвэл санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах оновчтой тогтолцоог бүрдүүлснээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох боломж бий. Ингэснээр эмзэг давхаргад байгаа иргэд илүү хамгаалагдах, дундаж давхаргынхан ч эмзэг байдал руу унахгүй байх, цаашлаад бий болж буй өсөлтөд хувь нэмрээ оруулах, ашиг шимийг нь хүртэх боломжийг нэмэгдүүлдэг.

Таны ярианаас эдийн засгийн хүртээмжтэй өсөлт нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэр олон хүнд хүрч байгаагаас шалтгаалдаг гэж ойлголоо. Санхүүгийн хүртээмж дэлхийн улс орнуудад тэр дундаа Монголд ер нь хэр байна вэ?

-Монголын хувьд зарим тоон үзүүлэлтээр дэлхийн дунджаас хавьгүй өндөр байх нь бий. Тухайлбал, 15-аас дээш насны иргэдийн 90% гаруй нь данс эзэмшлэг

гэсэн тоо нэлээд өндөр үзүүлэлт. Гэхдээ цаашид чанарын үзүүлэлтүүдийг сайжруулах, санхүүгийн бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг нь чухал юм. Дэлхийд 2 тэрбум орчим хүн санхүүгийн ямар нэгэн үйлчилгээ авч чадахгүй нөхцөл байдалд байна. Эдгээрийн дийлэнх нь хөгжиж буй орнууд, ядуу буурай орны иргэд. Энэ нь мэдээж том эрсдэлийг бий болгох магадлалтай. Тухайлбал, өвчин дэлгэрэх, эсвэл гал түймэр, осол аваар гэх мэт эрүүл мэнд, эд хогшилд том эрсдэл учирсан үед даатгалгүйгээс болж санхүүгийн том дарамтанд унах, улмаар ядууралд гүнзгийрэн орох тохиолдол бий. Түүнчлэн орлого зарлагаа зөв хуваарилах, хуримтлал үүсгэх, эрсдэлээ оновчтой удирдах, шаардлагатай үедээ санхүүжилт авах г.м. санхүүгийн олон хэрэгсэл, үйлчилгээний гадуур үлдэх нь тухайн хүндээ ч, эдийн засагтаа ч хохиролтой. Тийм учраас санхүүгийн хүртээмж чухлыг яриад байгаа. Гэхдээ энэ байдал мэдээж сайжирч байна. Тухайлбал, 2011 онд дэлхийн хүн амын тэн хагас нь санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байна гэсэн статистик үзүүлэлт гарч байсан. Тэгвэл ердөө 3 жилийн дотор энэ үзүүлэлт 30% руу орж буурсан байдаг. Үүнд нэг талаар интернет, ухаалаг төхөөрөмжүүд дэлгэрсэнтэй холбоотойгоор санхүүгийн хямд бүтээгдэхүүн, үйлчилгээний тархалт хүчтэй нөлөөлсөн. Мөн өмнө хэлсэнчлэн олонх улс орон, олон улсын байгууллагууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад идэвхтэй ажиллаж байгаа нь ч томоохон түлхэц болсон гэж дүгнэж болно.

Төр хэдийгээр зохицуулагч ч гэлээ бүхнийг шийдвэрлэх боломжгүй шүү дээ. Иргэд, хэрэглэгчид тэгвэл өөрсдөө юунд анхаарах нь зүйтэй вэ?

-Тийм. Тухайн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулж хэрэгцээ шаардлагаа хангах гэж байгаа хүн бол хэрэглэгч өөрөө шүү дээ. Иймд иргэд санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлж, өөрийн эрх ашиг, сонирхолд нийцсэн сонголтыг хийж чаддаг байх нь чухал. Мөнгө хөрөнгө, хүн хүч, мэдлэг туршлага гээд маш их нөөц чадалтай санхүүгийн байгууллагын үүдээр ороод, ширээний 2 талд сууж байгаад тэгш хэлцэл хийхийн тулд хэрэглэгчид санхүүгийн мэдлэг, боловсрол шаардлагатай. Үүнд туслах зорилгоор төрөөс дэмжиж болно. Тухайлбал, манайд хэрэгжиж байгаа санхүүгийн боловсролын хөтөлбөрийн гол зорилго энэ шүү дээ. Зохицуулагчийн зүгээс мэдээж хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлынхаа хүрээнд санхүүгийн байгууллагуудад тодорхой стандарт, хэм хэмжээг мөрдүүлж ажиллуулна. Дээр нь санхүүгийн салбарыг үр ашигтай, найдвартай байлгах дэд

бүтцүүдийг нь хийж өгнө. Тухайлбал, зээлийн мэдээллийн санг хөгжүүлснээр хэрэглэгчийн талаар үнэн зөв мэдээлэл банкуудад хүрнэ. Ингэснээр сайн түүхтэй, эрсдэл багатай хүн бүр бага хүүгээр зээл авах боломж нээгдэнэ гэсэн үг.

Тэгэхээр санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр шинэчлэл өрнөж байна гэж ойлголоо. Цаашид тогтолцоогоо боловсронгуй болгоход юу хийх ёстой вэ?

-Сайн тогтолцоо мэдээж институци, хууль эрх зүйн орчноос эхэлнэ. Өмнө хэлсэнчлэн, сая Төв банкны тухай хуулинд орсон өөрчлөлтөд энэ сэдэвтэй холбоотой зүйл заалт ч багтсан. Цаашид Монголбанк 2018 онд багтаан санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулан УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дэмжлэгтэйгээр УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэх зорилготой ажиллаж байна. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг зохицуулах үүрэгтэй гол байгууллагууд ямар тохиолдолд юу хийж чадах вэ, юу хийх үүрэгтэй вэ гэсэн өөр өөрийн чиглэлээр эрх үүрэг нь тодорхой байснаар ажлын уялдаа, үр дүнтэй байдалд шууд нөлөөлнө. Санхүүгийн харилцагч иргэд ч эрхийнхээ хувьд илүү баталгаатай бас хамгаалалттай болно гэсэн үг. Түүнчлэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд маань ил тод, үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдээ хангах, бизнесийн сайн туршлагыг нэвтрүүлж хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай. Аливаа санал гомдол, маргааныг хүндрэл багатай түргэн шуурхай шийдвэрлэх үйл явц, дотоод зохион байгуулалт ч үүнд хамаарна. Иймд боловсон хүчний мэргэжлийн ур чадвар, ёс зүйгээс эхлээд үйл ажиллагааны дүрэм журам чанартай байх хэрэгтэй. Тэгээд үүнийг нь дотооддоо хэрэгжүүлж, хөндлөнгөөс хянадаг сайн тогтолцоо бүрдүүлэх нь чухал юм. Хянаана, зохицуулна гэдэг нь бизнесийн байгууллагуудад хүндрэл дарамт учруулах бус, харин тодорхой байдлыг бий болгох, эрсдэлээс сэргийлэх, өрсөлдөөн – инновацийг дэмжих зөв сэдлийг төрүүлэх дүрэм л гэсэн үг. Хэрэв санхүүгийн байгууллагын ажилтан хүн бизнесийн сайн арга барилаар, мэргэжлийн өндөр ёс зүйн хэм хэмжээнд ажлаа хийж гүйцэтгэж харилцагчдаа ч, өөртөө ч ашигтай бизнес хийж байвал зохицуулагчийн зүгээс заавал хатуу дүрэм тогтоогоод, хянаж шалгаад байх хэрэгцээ шаардлага бага шүү дээ.

Ярилцсанд баярлалаа.

Т.Түвшинжаргал

"Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах" аян

Өнөөгийн нөхцөл байдал



Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь тус тусын хяналттай ч санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах функцийг хувьд давхардалтай, хамтын ажиллагааны механизм байхгүй буюу олон улсын хандлагад нийцэх нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр Монголбанк Азийн хөгжлийн банктэй "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулав.

- Монголбанк, бусад эрх бүхий байгууллагын санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чадавхийг бэхжүүлэх
- Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцоог сайжруулах
- Санхүүгийн салбарт маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

ADB

"Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах" аян

Цаашдын зорилт



Зохистой харьцааг хангуулах
хяналт шалгалт дангаараа оршдог байсан



Хэрэглэгчийг хамгаалах хяналт
шалгалтыг цаашид нэвтрүүлнэ

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11 зарчим



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь хуулиар зохицуулагч байгууллагын журам болон хяналт шалгалтын хүрээнд хамгаалагдсан байна.



Зохицуулагч байгууллага нь үйл ажиллагааны сайн засаглалтай, бие даасан, хараат бус, ил тод байна.



Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч ("СҮҮ") нь бүх хэрэглэгчидтэй тэнцүү, шударга, үнэнч харилцаж, байгууллагын сайн засаглалыг хэрэгжүүлнэ.



СҮҮ нь өөрийн бараа үйлчилгээний талаарх мэдээлэл, цаашлаад хүртэж болох ашиг, эрсдэл, бусад нөхцөлийг багтаасан бүрэн мэдээллийг олгоно.



Бүх оролцогчид санхүүгийн боловсролыг түгээж, хэрэглэгчдэд чиглэсэн мэдлэг, чадвар, дадал олгох үйл ажиллагаа явуулна.



СҮҮ нь өөрийн ашиг сонирхлоос илүү хэрэглэгчийн тусын тулд ажиллаж, бизнесийн ёс зүйг хангана.



Хэрэглэгчийн хадгаламж, харилцах данс болон бусад бүх хөрөнгийг луйвар болон зүй бусаар ашиглахаас сэргийлж, хамгаална.



Хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээллийг хууль, журмын хүрээнд хамгаалсан тогтолцоотой байна.



Хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх тогтолцоотой байж, энгийн хялбар аргаар зардал, хүнд суртал багатайгаар гомдлыг барагдуулна.



Санхүүгийн үйлчилгээний чанар, сонголтыг сайжруулж өрсөлдөөний зарчим дээр тогтдог болгосноор хэрэглэгчийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.



Хэрэглэгчийн гомдлыг шударга, үр дүнтэй, түргэн шуурхай барагдуулах стандарт, механизмтай байна.



/Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы "Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган"-ыг нээж хэлсэн үг/

2018.01.19 Орхон аймаг

Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга болон Монголын санхүүгийн зах зээлийн гол зохицуулагч, оролцогч байгууллагуудын төлөөлөл, эрхэм зочид төлөөлөгч Та бүхэндээ Монголбанкны нэрийн өмнөөс талархлаа илэрхийлье!

Шинэ оны эхэнд бид ажил хэрэгчээр ийнхүү уулзаж байгаа нь улс орныхоо эдийн засаг, санхүүгийн секторт шийдвэрлэх асуудлуудаа ярилцах, нэгдсэн гарц гаргалгаанд хүрэх үнэтэй боломжийг бүрдүүлнэ гэж найдаж байна.

Өнгөрсөн 2017 он бол Та бидний хувьд эдийн засгаа тогтворжуулж чадсан маш чухал жил байлаа. Амаргүй ч жил байсан. Дефолт, ханшийн огцом савлагаа, санхүүгийн системийн хямрал, эдийн засгийн уналт., магадгүй үүнийг

даган нийгмийн тогтворгүй байдалд ч хүрч болох аюултай нүүр тулахад ойрхон байв. Дахиж ийм сорилт, ийм хүнд үетэй Монгол орон бүү тулгараасай!

Та бид хамтын зүтгэлээр саад бэрхшээлийг давж гарч чадсан. Өнөөдөр төлбөрийн тэнцэл, валютын нөөц, богино хугацааны өрийн дарамт, зээлжих зэрэглэл, өсөлт гээд эдийн засгийн олон үзүүлэлт дээр эерэг хандлагууд ажиглагдаж, зах зээл дээрх итгэл сэргэж эхлээд байгааг бид бүхэн харж байна. Энэ бол Та бидний хөдөлмөрийн, зүтгэлийн үр дүн юм.

Эдийн засагт тулгарсан аюул, эрсдэлүүд биднээс түр холдсон ч цаашид хийх ажил нөр их байна. 2018 он бидний хувьд бий болсон эерэг өөрчлөлтөө бататгаж, ирээдүйн тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх маш чухал жил юм. Макро түвшний таатай өөрчлөлтүүдийн үр өгөөж нийгмийн өргөн хүрээнд мэдрэгдэхийн тулд энэ жил юу хийж хэрэгжүүлэх вэ гэдэг шийдвэрлэх нөлөөтэй байх болно.

Өнөөдөр Та бүхэнтэй уулзсан энэхүү завшааныг ашиглан дараах 3 зүйлийн талаар өөрийн санаа бодлоо хуваалцъя.

2018 он бол шинэчлэл, реформын жил

Хүндрэлийг даван туулах, цаашдын тогтвортой хөгжилд реформ чухал

Хямрал хүндрэлээс аливаа улс орон сургамж авч, алдаа дутагдлаа засаж залруулах ёстой. Манай улсын хувьд 2009 онд тулгарсан хямралын үед хийсэн шинэчлэл өөрчлөлтүүдээ тууштай хэрэгжүүлэх, бүрэн ажил хэрэг болгох зүтгэл дутсанаас өнөөгийн хүндрэл үүссэн юм. Бидний даван туулахыг зорьж буй эдийн засгийн энэ хүндрэл бол цар хүрээний хувьд, үргэлжилсэн хугацааны хувьд 90-ээд оны хүнд хэцүү жилүүдээс хойш тулгарсан хамгийн том сорилт болж байна. Угийн эмзэг бүтэцтэй эдийн засагт алсын хараагүй, тогтворгүй бодлого явуулсны хор уршиг л ингэж хүндээр мэдрэгдсэн гэж дүгнэж болно. Тухайлбал:

Төсвийн сахилга бат алдагдаж, 2013 оноос хойш улсын сан хөмрөг өндөр алдагдалтай явж ирэв. ДНБ-ийн 2%-аас хэтрэх ёсгүй төсвийн алдагдал 2 оронтой тоогоор хэмжигдэх болсон;

Өрийн оновчтой удирдлага, хяналттай зарцуулалт байгаагүйгээс болж улсын сектор эдийн засгийн хэмжээтэйгээ тэнцэхүйц өртэй болов. Гаднаас татсан санхүүжилтүүдийн ашиг тус нь төдийлөн мэдрэгдээгүй хэрнээ их наяд төгрөгөөр хэмжигдэх хүүний зардал төлж байгаа нь татвар төлөгчид томоохон дарамт болж байна;

Төв банк хараат бус байдлаа алдаж, зах зээлийн бус хэлцлүүд ихээр хийсэн нь ёс зүйн гажуудал (moral-hazard), нөөцийн үр ашиггүй хуваарилалт, хөрөнгийн үнийн хөөсрөл, гадаад валютын нөөцийн хомсдол, төв банкны алдагдал, төгрөгийн ханшийн огцом савлагааны гол шалтгаан болов;

Нийтийн эрх ашигт нийцэхгүй хувийн инсентив, улс төржилт, популизмаас болж мега төслүүдээ гацааж, хөрөнгө оруулагчдаа үргээсэн нь цаг хугацаа алдаж, улс орны нэр хүндийг унаган, асар их хэмжээний алдагдсан боломжийн өртгийг үүсгэв;

Эдгээр бодлогын алдаа нь гадаад секторын сөрөг шоктой нийлээд төлбөрийн тэнцлийн архаг хүндрэл болсон. Улмаар төлбөрийн тэнцлийн, банкны секторын, үндэсний мөнгөн тэмдэгтийн гурвалсан хямралд орох эрсдэлд хүргэв.

Энд өнгөрснийг шүүмжилж, одоо цагаа үрэх нь бидний зорилго биш ээ. Харин бидний хийх ёстой зүйл бол хүндрэлийн шалтгаан болсон эдгээр алдаа дутагдлууд дээр шаардлагатай бүх өөрчлөлт тохиргоо, засваруудыг хийж, цаашид өөрчлөлт шинэчлэлээ тууштай хэрэгжүүлэх явдал билээ.

Реформ хийх цаг хугацаа нь яагаад заавал 2018 он бэ?

Хэдийгээр одоо бид ангал руу унах аюулаас аврагдсан ч, хавцлын ирмэг дээрээс тийм ч холдоогүй байна. 2017 он бол олон улс орны хувьд дэлхийн эдийн засгийн хямралаас хойшхи 10 жилд тохиосон хамгийн таатай жил болсон. Сэргэлт 2018 онд ч үргэлжилж, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжрах төсөөлөлтэй байна. Нэг талаар бидэнд ийнхүү аз тохиосон ч, хөдөлмөр зүтгэлийг аз ивээдэг юм. Гэхдээ гадаад орчны энэхүү эерэг нөлөөг бид үүрд үргэлжилнэ гэж бодож болохгүй. Учир нь:

Томоохон эдийн засгуудын мөнгөний бодлогын төлөв чанарахтай холбоотойгоор өнгөрсөн жилүүдэд олон улс орнуудад бий болсон өрийн ачаалал, дарамт нэмэгдэх төлөвтэй байна;

Дэлхийн эдийн засгийн хямралын дараах мөнгөний хүчтэй тэлэх бодлогын үр дүнд улс орнуудын хөрөнгийн зах зээл дээр бий болсон хувьцааны үнийн өсөлт эргэж засварлагдан, савлагаа үүсгэх эрсдэл байна;

Зөвхөн хөгжсөн төдийгүй, зарим гол хөгжиж буй орнуудад хурдтай явагдаж буй хүн амын насжилт, бүтээмжийн бууралт нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг дунд, урт хугацаанд дэмжихээргүй байна;

Дээр нь геополитикийн асуудлууд, протекционист эдийн засгийн бодлогууд экспортлогч орнуудад, ялангуяа сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол зүтгүүр болсон Азийн орнуудад сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Тэгэхээр, “үүлэн чөлөөний нар гийсэн” яг энэ таатай цаг үеэр бид шаардлагатай өөрчлөлтүүдээ хийх хэрэгтэй. Энэ л боломжийг ашиглан эдийн засгаа эрүүлжүүлэх, хүндрэлийн шалтгаан болсон гажуудлуудыг арилгах, эдийн засгийг илүү дархлаатай болгох шинэчлэл, реформуудаа хийх учиртай.

Бидний хамтын ажиллагаа

2018 онд зээлжих зэрэглэлээ өсгөх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тогтолцоогоо сайжруулан

“саарал жагсаалт”-д орох эрсдэлээс гарах, өрийн дарамтаа бууруулах, валютын нөөцөө үргэлжлүүлэн нэмэгдүүлэх зэрэг тодорхой зорилгууд, сорилтууд бидний өмнө бий. Түүнчлэн түүхий эдийн үнийн уналтын дараагийн цикл, эдийн засгийн хүндрэлд ч бэлтгэлтэй байх нь чухал. Үүний тулд банк санхүүгийн сектор, татварын бодлого, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого гээд олон чиглэлээр томоохон реформууд, тогтолцооны шинж чанартай өөрчлөлтүүдийг ч хийх шаардлага тулгарч байна.

Энэ бүгдийг амжилттай хийж, хэрэгжүүлж, зорьсон үр дүндээ хүрэхийн тулд бидэнд нэгдсэн ойлголцол, хамтын ажиллагаа, бодлогын уялдаа хэзээ хэзээнээс илүү чухлаар тавигдаж байна.

Монголбанкны хувьд, эдийн засагт хувь нэмэр оруулах шинэчлэл өөрчлөлтүүдээ төлөвлөөд, эхнээс нь хийгээд явж байгаа билээ. Тухайлбал:

Монголбанк инфляцийг нам тогтвортой байлгах үндсэн зорилгоо амжилттай биелүүлэхээр бодлогын, үйл ажиллагааны цогц өөрчлөлтийн стратеги боловсруулаад хэрэгжүүлээд явж байна. Төв банкны тухай хуулийн өөрчлөлтөөс эхлээд, дотоод бүтэц зохион байгуулалт, засаглалын оновчтой хувилбар, бодлогын шинэ арга хэрэгслүүдийн судалгаа шинжилгээ, хүний нөөц боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтүүд үүнд хамаарах юм.

Мөн банк санхүүгийн салбарын эрүүл найдвартай байдлыг хангах гол зорилгынхоо хүрээнд санхүүгийн секторыг зохицуулж буй хууль эрх зүйн орчны цогц шинэчлэл, Төв банкны хяналт шалгалтын тогтолцооны өөрчлөлт ч давхар хийгдээд явж байгаа.

Гэхдээ Төв банк хийж чадах зүйл гэж байгаа ч, дангаараа эсхүл огт хийж чадахгүй зүйлс ч бас бий. Эдийн засгийн эрэлтийн талыг зохицуулан, инфляцийн дарамтгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжсэн бодлого явуулах явдал бол Монголбанк эдийн засагтаа оруулах хамгийн том хувь нэмэр юм. Өсөлт иргэдийн амьдралд наалдацтай байхад инфляци тодорхой түвшинд тогтвортой байх нь чухал билээ. Бидний зорьж буй “инфляцийн дарамтгүй эдийн засгийн тогтвортой өсөлт”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд Та бүхний шийдвэр, үйл ажиллагаа ч багагүй нөлөөлнө гэдгийг энд онцлох нь зүйтэй. Тухайлбал:

Санхүүгийн салбарт хийгдэх реформын суурь болсон хуулийн шинэчлэлүүд маань УИХ-аас шууд хамаарна;

Төв банкны гол зорилго болсон инфляци тогтвортой байхад Засгийн газрын төсвийн бодлогын нөлөөг харгалзан үзэх шаардлагатай байдаг;

Үнийн тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг валютын ханшийг тодорхойлж буй төлбөрийн тэнцэл өөрөө татварын бодлого, хөрөнгө оруулалт татах бодлого, эдийн засгаа төрөлжүүлэх бодлогоос шууд хамаатай.

Төв банкны мөнгөний бодлогоор зохицуулах аргагүй, эдийн засагт нийлүүлэлтийн талаас нь нөлөөлөх бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлж эхлэхэд Та бүхний хүчин зүтгэл туйлын чухал байна. Ялангуяа, төлбөрийн тэнцлийг тодорхойлдог экспортыг дэмжих, импортыг орлох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажиллах хүчний бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг олон тулгуурт, өрсөлдөх чадвартай болгох бодлогын бүтцийн реформууд үүнд хамаарах юм.

Бодлого, реформуудаа нийгэмд үнэн зөв ойлгуулах

Аливаа реформ, шинэчлэлийг ажил хэрэг болгох, тууштай үргэлжлүүлэхэд нэгдсэн хүлээлт, ойлголт, байр суурь маш чухал нөлөөтэй. Бид ажил үйлээ нийгэмд үнэн зөвөөр ойлгуулж дэмжлэг авахгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь өнгөрсөн жил гаруйн хугацаанд олон жишээгээр тод харагдлаа.

Өөрчлөлт шинэчлэлт, эдийн засгийн эмчилгээ өөрөө амаргүй зүйл. Үргэлж амттай сайхан байх ч албагүй бөгөөд, гашуун хэдий ч уух ёстой эм мэт байдаг. Энэ үед мэдээллийн дутмаг, хомс байдал нь нийгэмд буруу ойлголт төрүүлэх, зүй бус няцаалт шүүмжлэлүүд газар авах, улс төрийн болоод бусад зорилготой дайралтууд идэвхжих нөхцөлийг бүрдүүлдэг. Улмаар сайн бодлого хэрэгжихгүй байх, хэрэгжихэд саад учрах өндөр эрсдэлүүдийг бий болгож байна.

Иймд бид хийсэн ажлаа, хийж буй зүйлээ, тэдгээрийн үндэслэл шалтгаан, зорилгоо идэвхтэй түгээх, үнэн зөвөөр тайлбарлаж ойлгуулах шаардлага зүй ёсоор урган гарч ирж байгаа юм.

“Ямар ч сайн бодлого тайлбарлахгүй бол ойлгогдохгүй, ойлгогдохгүй бол дэмжигдэхгүй” гэдэг үгээр би яриагаа өндөрлөө.

Та бүхэнд баярлалаа!


Зураг 3. Иргэд, хувийн хэвшлийн зээлийн өсөлт



Иргэд /МБС-д шилжүүлсэн байцаг оруулснаар/
Иргэд
Хувийн хэвцэр

Иргэдийн зээл, тэр дундаа цалин, хэргийн зээл өсөлттэй гарсан бол ажлын нэгжүүдийн зээлийн өсөлт сөрөг байна.


Зураг 4. Чанаргүй зээл, түүний өөрчлөлт



Чанаргүй зээл /түүний тэнцлэг/
Чанаргүй зээлийн жилийн өсөлт
Чанаргүй зээлийн жилийн өсөлт /Зорь, Хадгаламж Банкныг хэсгээр/
Чанаргүй зээлийн жилийн өсөлт /Зорь, Хадгаламж Банкныг хэсгээр/

Нийт чанаргүй зээлийн хэмжээ 2017 оны 2 дугаар хагаст биет хэмжээгээр өсөөгүй

Зураг 5. Инфляци, түүний өөрчлөлт



Сарын инфляци
Жилийн инфляци
Сүүрийн инфляци
Төрийн инфляци

Үйлдвэрлэл, инфляцийн дараахад эдийн засаг уналтын гарч сэргэлтийн төлөв байгаа

Эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв

Хүтээнэвч



Д.Ариунаа Монголбанкны
Олон нийтийн боловсрол мэдээллийн
төвийн ахлах мэргэжилтэн

ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ “АРГАМЖИХ” ХАРИУЦЛАГАТАЙ ЦАГ ИРЭЭД БАЙНА

Алдагдал нэвчсэн төлбөрийн тэнцэл, цааш гишгэх газаргүй болчихоод байсан гадаад өрийн тулсан дарамт, төгрөгийн ханшийн огцом уналт холдлоо. Ингэснээр эдийн засаг, бизнесийн орчинд уужим амьсгаа авах таатай нөхцөл бүрдэж эхэлж байна. Хямралыг ангал гэж зүйрлэх юм бол түүний ирмэгт нь хариугүй тулаад ирчихсэн байсан эдийн засаг өндийлөө. Мөнгөний бодлогын жолоо цулбуурыг зангидах Монголбанкнаас санаачилсан “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган”-ы яриа эндээс эхэлж, юуны өмнө нөхцөл байдлаа оношлов.

Өсөлтийн тухай ярихад ч хэтийдэж мэдэхээр хол үе бидэнд байв. Яг жилийн өмнөхөн, манай эдийн засаг уруудан доройтох “ангал”-ын зүг чөлөөт уналт хийж байлаа. Тэр үед ОУВС-тай хамтран гурван жилийн хугацаатай хөтөлбөр хэрэгжүүлэх тухай яриа хэлцэл ид өрнөж байсан билээ.

Харин өнөөдөр эдийн засаг тогтворжиж, 2017 оныг 2016 онтой харьцуулахад макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эхнээсээ сайжраад эхэллээ. Тэгтэй тэнцэх ДНБ-ий төлөв агшилтаас ангижирч, өсөлтийн замдаа шилжсэн байна. Бизнес эрхлэгчдийн итгэл сэргэж, хөрөнгө оруулагчдын хандлага наашиллаа. Өдөр ирэх тусам хорогдож байсан гадаад валютын албан нөөц өнгөрсөн саруудад зузаарч, дотоодын импортын хэрэглээний 8 сарын хэрэгцээг хангах түвшинд иржээ. Нөөц ийнхүү нэмэгдэх буухиа үргэлжлэх хэрээр ханшийн захын шуугиан эрс намжиж, урьдын хүндрэл бага багаар хумигдаж байна. Монгол Улс хоолой дээр тулаад байсан хоёр ч том гадаад төлбөрөө шийдчихээд байхад валютын нөөц жилийн өмнөхөөс гурав дахин өндөр үзүүлэлттэй гарав.

Санхүүгийн далайд гарсан анхны эрлээрээ Монгол Улс 2013 онд ДНБ-ийхээ 17 хувьтай тэнцэх хэмжээний

санхүүжилт авч байсан. Гэвч алдаатай бодлогын уршиг хөөсөрч явсаар хямралтай залгасан. Бодлогын орон зай туйлын хомс болчихсон энэ үед алдаагаа давтах бус бүсээ чангалж, зардлаа танахын зэрэгцээ төсөв, мөнгөний бодлогоо эргэн харж, улмаар тодотгоход хүргэсэн. Ингэснээр дэндүү эмзэг болчихсон эдийн засгийн “эрүүл мэнд” сүүлийн хоёр жилийн турш дамнан явуулсан бодлогын үр дүнд илааршиж, одоо л засал авч эхэлж байна.

Ангалын ирмэгээс ухарсан ч тайвшрах цаг болоогүй

Дараагийн алхмууд нь өмнөх алдаагаа давтахгүй байхад чиглэх ёстой гэдэг. Үүнийг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан чуулганы эхэнд тодотгоод, өнгөрсөн жилүүдэд хүндэрч, туйлдаад байсан эдийн засаг 2017 оноос сэргэж эхэлснийг онцолсон юм. Тэрбээр энэ үеийг үүлэн чөлөөний нартай адилтгасан нь тайвшрах цаг болоогүйг давхар сануулж, ангалын ирмэгээс 2-3 алхам л холдоод байна гэв.

Үнэхээр, онцолж хардаг үзүүлэлтүүд итгэл найдвар төрүүлж, 360 хоногийн өмнө эдийн засагт үүссэн байсан хүндрэл, бэрхшээл саармагжсан ч эргээд бий болох эрсдэл хэвээрэй гэдгийг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, СЭЗИС-ийн багш Ц.Батсүх мөн хэлсэн юм. Тэрээр “Эдийн засагт бий болсон эерэг үр дүнгээ улам баталгаажуулах, дунд, урт хугацаанд тогтвортой байлгах үндэс суурийг бүрдүүлэх шаардлага хэвээр байна” гэлээ. Ялангуяа, бодлогын өөрчлөлт, төсөв, санхүүгийн салбарын шинэчлэл, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, зохицуулалтыг сайжруулах сорилт бодлого боловсруулагчдын өмнө тулгарч байна. Амаргүй жилийн ард Монгол Улс гарсан ч сэдэрч мэдэх тоонууд толгой дараалан байсаар буй.

Тухайлбал, төсвийн орлогын бүтэц уул уурхайн салбараас үлэмж хамааралтай байгаа нь эдийн засаг “чилээрхэх” шалтгаан болдог. Дэлхийн санхүүгийн болон бараа, бүтээгдэхүүний зах зээл дэх үнийн хэлбэлзлээс орлогын эх үүсвэр болсон салбарын хараат байдал улам бүр нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн эдийн засаг “ханиад хүрэх” үед Монгол Улс “хатгаа авчихдаг”. Энэ байдал нь даамжирсаар өсөлт саарч, өрөө тэлэхэд хүргэдэг гэмтэй. Энэ асуудлыг “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган” орхисонгүй. Хөндөх ёстой сэдэв учраас тал бүрээс нь нухацтай дүн шинжилгээ хийлээ. Манай улсын хувьд эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатайг

хэн хүнгүй анхааруулдаг. Тэр дундаа Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк хүртэл байнга сануулж ирсэн удаатай.

Тухайлбал, экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ 2011 оны сүүлээс эхлэн унасан. Үүнтэй зэрэгцэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2012 оноос татарсан. Эцэст нь, эдийн засгийн идэвхжил суларч, өсөлт саарсан. Энэ үед эдийн засгийн идэвхжлийг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор төсөв, мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлсэн. Энэ бодлого нь богино хугацаандаа үр дүнтэй байж эдийн засгийн өсөлт тодорхой хугацаанд өндөр түвшинд хадгалагдсан хэдий ч эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, дунд хугацаандаа эдийн засгийг эргээд илүү том хүндрэлд оруулсан гашуун түүх хуучраагүй байна. Эдийн засагт хуримтлагдсан алдагдал одоо ч сөрөг нөлөөллөө хадгалсаар байгаа юм.

Тогтвортой өсөлтийн “хөрс”

Монгол Улсын зээлжих зэрэглэл “эрсдэлтэй”-гээс “тогтвортой” руу шилжлээ. Энэ нь хөрөнгө оруулалтын орчинд сайны дохио болсон. Үүнээс гадна өнгөрсөн оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт 4.9 хувиас багагүй байхаар урьдчилсан тооцоо гарч байгааг чуулганд оролцсон Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа онцоллоо. Эдгээр нь эдийн засаг эргээд сэргэж байгааг гэрчилнэ. Гэсэн ч гадаад өрийн эргэн төлөлт, ядуурал, өрхийн зээлийн дарамт анхаарлын төвд хэвээр байна. Энэ байдлын эсрэг “Төсөв, мөнгөний бодлого уялдаатай байх нь манай улсын эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн оновчтой арга” хэмээн Ерөнхий сайдын ахлах зөвлөх Н.Энхбаяр тодорхойлсон юм.

Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал Д.Ган-Очир Монголын эдийн засагт тулгарч буй 3 том сорилтын эхэнд өр төлбөрийн дарамтыг нэрлэлээ. Түүний илтгэлд, Монгол Улсын нийт гадаад өр 26 тэрбум ам.долларт хүрч, өр, ДНБ-ий харьцаа сүүлийн таван жилд хоёр дахин өссөн гэх тоо дурдагдав.

Дэлхийн банк, ҮСХ-ны хамтарсан судалгаагаар сүүлийн хоёр жилийн дотор манай улсын ядуурлын түвшин 29.6 хувьд хүрч, 275 мянган хүн ядуурлын шугамаас доош унасан байна.

Тиймээс өсөлтийг тогтвортой, хүртээмжтэй аргамжих нь чухал гэдгийг хэлээд байгаа юм. Үүний тулд бүтээмжийн асуудлыг анхаарах ёстой. Бүтээмжээ дээшлүүлж байж өрхийн орлого нэмэгдэж, өсөлт бодитой болно гэдгийг УИХ-ын даргын эдийн засгийн зөвлөх Ц. Мөнхбаяр хэлж

байсан нь төрийн бодлогод тусгалаа олох ёстой шийдэл билээ. Мөн уул уурхайгаас хамааралтай манай улс маш ухаалаг, маневр сайтай, зөв төлөвлөсөн дипломат харилцаа чухал нөлөөтэй, цаашид эдийн засгийн төрөлжүүлэх бодлогыг цаг алдалгүй хийх шаардлагатай гэсэн санааг хэд хэдэн оролцогчид илэрхийлж байсан нь өнгөрсөн жилүүдэд экспорт татарч, хөрөнгө оруулалт буурч, төгрөгийн ханш хүчтэй савалснаас үүдсэн дүгнэлт байв.

Саарал жагсаалтаас холуур байхын учир

Эрсдэлээ тодорхойлж, бодлогоо зурагласан чуулганаар мөнгө угаах болон терроризмийн эсрэг дэмжих үйл ажиллагаа, криптовалют, цахим мөнгийг хэлэлцсэн юм.

Тус салбар хуралдаанд оролцсон Хууль зүйн дэд сайд Б.Энхбаяр Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хууль тогтоомжоо сайжруулах нь маш чухал, тулгамдсан асуудал болоод байгааг хэлсэн юм. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн бүсийн бүлэг (APG)-ээс Монгол Улсыг “эрчимтэй хяналтад” оруулсан. Монгол Улс энэ оны аравдугаар сараас өмнө холбогдох хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжилтийг нь хангах үүрэг хүлээсэн. Энэ үүргээ биелүүлэхгүй байх нь “саарал жагсаалт”-д орох үр дагавартай бөгөөд санхүүгийн системд ноцтой эрсдэл учрах, банкны гадаад гүйлгээг зогсох, зардал нь эрс нэмэгдэх эрсдэлтэй юм. Тиймээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд онцгой анхаарах шаардлага үүсээд байна.

Цахим хувьсгал буюу технологийн эрин

Технологийн дэвшил нь эдийн засгийн олон секторт нөлөөлж байгаагийн нэг нь санхүүгийн салбар. Санхүүгийн технологи нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэ шатанд гаргаж байна. Тэрчлэн санхүүгийн зуучлалын өртгийг бууруулж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран

санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байгаа юм. Хэдийгээр энэ нь олон боломж шинээр нээж байгаа хэдий ч бодлого боловсруулагчдын өмнө олон сорилтуудыг мөн нээж байна. Дэлхийн санхүүгийн түүхээс харахад санхүүгийн инноваци, инженерчлэл зэрэг нь хүндрэл, хямралыг дагуулсан байдаг.

Сүүлийн жишээ гэхэд, Моргэйжийн үнэт цаасжуулалт нь дэлхийн санхүүгийн хямралд хүргэсэн. Үүнээс авах гол сургамж нь санхүүгийн хяналт, зохицуулалт шинэчлэл болон тогтвортой байдлын хоорондын тэнцвэрийг хангасан уян хатан байх явдал. Түүнчлэн төлбөр тооцооны систем нь шинэ аргууд болон хэрэглэгчдийн зан төлөвт гарч буй өөрчлөлттэй уялдан хувьсан сайжрах ёстой болж байна. Мэдээллийн технологийн хувьд кибер аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналаас сэргийлэх нь чухал болов.

Цахимжиж буй орчинд төв банкууд мөнгө гэдэгт юуг ойлгохыг дахин эргэн харах шаардлага гарлаа. Криптовалют, ухаалаг гэрээ зэрэг блокчэйн суурилсан технологийн өөрчлөлтүүд, дижитал мөнгө зэргийг хэрхэн зохицуулах вэ гэсэн шинэ сорилт ч тулгарч байна. Энэ болгонд тодорхой хариулт өгч, эерэг үзүүлэлтээ бататгахын сацуу эдийн засгийн шийдэмгий бодлого хэрэгжүүлбэл тулгарч буй сорилтыг даван гарах боломжтой гэдэг дээр оролцогчид санал нэгдсэн юм.

Эдийн засаг, макро бодлогод тулгарч буй сорилт, бэрхшээлд шийдэл хайх, бодлогын боломжит хувилбаруудыг судалж хэлэлцсэн энэхүү чуулганыг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар Монголбанк зорьж байна. Монголын эдийн засгийн бодлогын чуулганыг эс тооцвол замын зураглалаа хэлэлцдэг ийм индэр манай улсын хувьд учир дутагдалтай хэвээр байгаа билээ. Эдийн засгийн чуулган ирэх жилийн өдйд 2018 оны бодлогын хэрэгжилт, алдаа, оноог үнэлж цэгнэнэ. Тэр үед өнөөдрийн гаргасан амжилтаа бэхжүүлж, өсөлтөө тогтвортой хадгалсан байх нь тэргүүн зорилт болоод байна.

Төв банкууд эдийн засгийн замын зураглалаа гаргах жилийн уулзалтыг шийдвэр гаргагчид, санхүүгийн оролцогчдын хамт хийх нь нийтлэг. Монгол Улсын төв банк ч мөн үүн тийш зорьж, “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган”-ыг зохион байгуулсан нь санхүүгийн урт хугацааны тогтвортой байдал, эдийн засгийн жигд өсөлтийг хангах уялдаатай бодлого шийдвэрийн төлөө зорьж буйд юм. Энэ үеэр чуулганы төлөөлөгчдөөс дэвшүүлсэн санал, дүгнэлтийг “байр суурь” буландаа онцолж байна.



Н.БАЯРТСАЙХАН: Монголбанкны Ерөнхийлөгч

Бодлогын зоримог шийдвэрүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд манай улсын эдийн засагт маш олон өөдрөг үзүүлэлт гарч, эерэг хандлагууд ажиглагдаж байна. Ингэснээр зах зээл дэх итгэл сэргэж, эдийн засагт тулгарсан аюул, эрсдэлүүд биднээс түр холдсон ч цаашид хийх ажил маш их байна. 2018 он бол бидний хувьд бий болсон эерэг өөрчлөлтүүдээ бататгаж, тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх маш чухал он буюу шинэчлэл, реформын жил болох ёстой гэж үзэж байна. Энэ оныг бид үлэн чөлөөний нар гийсэн үетэй адилтгаж эдийн засгийн өөд нь татах ёстой.



Н.ЭНХБАЯР: Ерөнхий сайдын зөвлөх

Бид экспортын биет хэмжээгээ өсгөж болох байсан. 2015 онд 15.5 сая тонн нүүрс экспортолж, 550 сая ам.долларын орлого олжээ. Гэтэл 2017 онд 33 сая тонн нүүрс экспортолж 2.2 тэрбум ам.долларын орлого олсон. Үнийн нөлөөлөл байгаа ч бид нүүрсний биет хэмжээг 2 дахин, орлогыг 4 дахин өсгөж болж байна. Энэ бол хангалттай тоо. Үнэ, биет хэмжээ гэсэн хоёр хувьсагчийн нэг нь биднээс хамаарч байгаа. Нэг хувьсагчаа бид жолоодох боломжтой. 2017 онд жолоодсон учраас бид амжилтад хүрсэн. Энэ бол гадаад худалдаа, төсөв, экспортоо дэмжих бодлого. Төсвийн алдагдлаа бид гадаадын зээл тусламжаар санхүүжүүлж байгаа гэдгээ тайлбарлах хэрэгтэй. Ойрын хугацаанд бидний хэрэгжүүлэх боломжтой бодлого бол эдийн засгийн төрөлжилтөөс гадна экспортын төрөлжилт юм.



О.ОРХОН: ХХБ-ны гүйцэтгэх захирал

Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн хувьд арилжааны банкуудад хэрэгцээтэй тохиолдолд, шаардлагатай салбарт хөрөнгө оруулах нь зүйтэй. Ялангуяа, хөрөнгийн зах зээл нь хөгжөөгүй, зөвхөн дотоодоосоо эх үүсвэрээ хангадаг Монгол шиг улсын төв банк мөнгөний нийлүүлэлт хийх нь зүйтэй. Төсөв, мөнгөний бодлогоо хумьж, бусад үед чөлөөлж, тэнцвэрээ хадгалсан бол ийм нөлөө гарахгүй байсан.



Ц.ТҮМЭНЦОГТ: “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал

Төв банкны зохион байгуулж буй чуулганыг цагаа олсон үйл явдал гэж үзэж байна. Монгол Улсад валютын урсгалын хяналт алга. 2017 онд “Эрдэнэс таван толгой”-гоос Гашуунсухайт боомтоор 20 сая тонн нүүрс тээвэрлэсэн. Ингээд бодоход 400 сая ам.долларын тээврийн зардал Хятад руу урссан. Үүнийг Монгол Улс мэдээгүй. “Оюутолгой” өнгөрсөн жил 160 гаруй сая ам.долларыг цахилгаан, эрчим хүчинд зарцуулсан. Монгол Улс жилд бензин, шатахуун худалдаж авахад 0.8-1 тэрбум ам.доллар зарцуулдаг. Том том уул уурхай, цахилгаан түлшинд хэдэн тэрбумаар урсаад алга болчихдог. Тэгэхээр хамгийн түрүүнд яг бодит эдийн засагт мөнгөн урсгал хаашаа явж байна гэдгийг тогтоох ёстой.



Ц.МӨНХБАЯР: УИХ-ын даргын эдийн засгийн зөвлөх

“Одоо бидэнд тулгамдаад буй хоёр сорилт байна гэж би харж байна. Нэгдүгээрт, одоо бий болоод буй эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, хоёрдугаарт өсөлтийг хүртээмжтэй буюу өрхөд бий болгох. Хүртээмжтэй байлгахын тулд бид өрх гэрт тэгш боломжийг нь бий болгох хэрэгтэй. Ажлын байрыг бий болгохын тулд бүтээмжийн асуудал яригдана. Бүтээмжийн асуудал сүүлийн жилүүдэд олигтой явахгүй байна. Бүтээмжээ дээшлүүлж байж өрхийн орлого нэмэгдэж, өсөлт бодитой болно. Бид том зорилтуудаа тавьсан ч дараагийн бодлогууд хурдан гарахгүй болохоор эрсдэл гарч байна. Мөн бодлогын хэрэгжилтийг хянах тал дээр дутуу ажиллаж байгаа. Үүнээс гадна бид бодлогоо олон нийтэд зөв танилцуулж байх нь чухал. Тэгвэл хүлээлтийг зөв удирдаж чадна”

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС



ЦАГИРАГ ХЭЛБЭРТЭЙ АЛТАН ЭЭМЭГ

Доороо сэнжтэй алтан ээмэг. 1973 онд Увс аймгийн Чандмань сумын Чандмань уулын булшнаас илэрчээ.

Хүннүгийн үе /НТӨ III-НТ I зуун/

Жин: 3.2 гр

Хэмжээ: 3.1x3 см

СЭНЖТЭЙ АЛТАН ЭЭМЭГ

1978 онд Архангай аймгийн Батцэнгэл сумын Баян-Уул багийн нутаг Шивэртийн амны 3-р булшнаас илэрчээ.

Хүннүгийн үе /НТӨ III-НТ I зуун/

Жин: 1.85 гр

2.8x2.4 см



СУВДАН УНЖЛАГАТАЙ АЛТАН ЭЭМЭГ

Сувдан унжлагатай, дэгээ хэлбэрийн алтан ээмэг. Археологич Д.Наваан дундговь аймгийн Сайхан-Овоо сумын замбага хайрханд малтсан XIII-XIV зууны үеийн монгол булшнаас илрүүлжээ.

XIII-XIV зуун

2.64x1.56 см

ЦАГИРАГ ХЭЛБЭРТЭЙ АЛТАН ЭЭМЭГ

1980 онд Сэлэнгэ аймгийн Хонгорын САА-д малтсан Хүннүгийн 4-р булшнаас илрүүлжээ.

Хүннүгийн үе /НТӨ III-НТ I зуун/

Жин: 3.2 гр

Хэмжээ: 3.1x3 см





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... /2018.01.25/

Монголбанкны бодлого, шийдвэр, цаг үеийн мэдээллээр сар тутамд мэдээлэл өгдөг “Монголбанкны мэдээлэл” хэвлэлийн бага хурал 2018.01.25-нд боллоо. Хэвлэлийн бага хурлаар уламжлал ёсоор банк, санхүү эдийн засгийн сарын статистикийг танилцуулж, шинэчлэгдэн батлагдсан Төв банк (Монголбанк) –ны тухай хууль, Банкны тухай хуулийн талаар мэдээлэл хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өглөө. Хурлын тэмдэглэлийн дэлгэрэнгүйг толилуулж байна.

Өдрийн сонин: Инфляцийн хүлээлтийн судалгааны талаар асууя. Аж ахуйн нэгжүүдийн хувьд инфляцийг 4.6 хувь гэсэн байхад иргэдийн судалгаан дээр яагаад 8 хувь гэж гарсан байна. Энэ хоёр хүлээлт яагаад ийм их зөрүүтэй гарч байна вэ?

Судалгаа Статистикийн Газар /ССГ/-ын захирал Д.Ган-Очир:

Бид түүвэр судалгааны аргаар буюу 2000 иргэнээс асуусан санал асуулгын дүнг нэгтгэхэд, ийм үр дүн гарч байна. Тодруулбал, 2000 иргэнээс “Ирэх оны өдийд инфляци хэдэн хувьтай гарна гэж та бодож байна вэ?” гэсэн асуултыг асууж, хариултаа нэгтгэж үзэхэд дунджаар 8.1 хувьтай байна гэсэн үр дүн гарсан. Яг үүнтэй адил асуултыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 100 орчим аж ахуйн нэгжийн удирдлага, менежерүүдээс асуухад хариулт нь 4.6 хувьтай байхаар төсөөлөл өгсөн. Тэгэхээр судалгаанаас гарч ирж байгаа үр дүнг л та бүхэнтэй хуваалцаж байгаа юм. Судлаачийн хувьд хэлэхэд, иргэдийн хариулт ихэвчлэн инфляци өндөр, валютын ханш сулрах хүлээлттэй байх үед инфляци өснө гэх хариултыг өгдөг. Нөгөөтэйгүүр Төв банкны зүгээс инфляцийг 8 хувьд байхаар зорьж байна гэх мэдээллийг

олон сувгаар өгч байгаа. Тэгэхээр иргэд маань гүнзгий дүн шинжилгээ гэхээсээ илүүтэй, сонссон мэдээлэл дээрээ үндэслээд хариулт өгөх байдал ажиглагддаг. Тэр утгаараа хариулт 8 хувь гэдэг тоо руу ойртсон байх магадлалтай. Аж ахуйн нэгжүүдийн хариултын тухайд өнгөрсөн хоёр жилийн хугацаанд инфляци нэлээд бага хувьтай байсан. 2016 оны гуравдугаар улиралд бүр дефляцитай байсан. Мөн сүүлийн хоёр жилийн дунджийг харвал зорилтот 8 хувиас нэлээд доогуур буюу 4 орчим хувьтай байгаа. Тэгэхээр аж ахуйн нэгжүүдийн шинжээч, менежерүүд эдгээр хүчин зүйлсийг үндэслээд, хариултаа өгсөн байх магадлалтай.

Өдрийн сонин: Монголбанкнаас өнгөрсөн жилүүдэд “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд ихээхэн хэмжээний мөнгө гаргасан. Үүний үр дүн гарсан уу. Тэр мөнгө эргээд төлөгдсөн үү?

ССГ-ын захирал Д.Ган-Очир:

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн талаар улстөржсөн болон эдийн засгийн талаас нь харсан маш олон тайлбар, дүгнэлтүүд байдаг. Эдийн засгийн бодлогын чуулганы нэгдүгээр хуралдааны үеэр энэ асуудал яригдсан.

Яригдсан нийтлэг зүйлүүдийг та бүхэнтэй хуваалцъя. Тэгэхээр оролцогчид буюу профессор, судлаачид ямар дүгнэлт хэлж байна вэ гэхээр “Яг үнэ тогтворжуулах хөтөлбөрт багтсан бүтээгдэхүүнүүдийн үнэ тодорхой хугацаанд тогтвортой байж чадсан байна” гэж байгаа. Гэхдээ тэр хөтөлбөрт хамрагдаагүй бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөх дарамтыг бий болгосон. Өөрөөр хэлбэл, нэг хэсэг бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулснаар Төв банкнаас олгосон санхүүжилтээс үүдсэн нийт эрэлт нь нэмэгдэж, валютын ханш суларснаар хөтөлбөрт хамрагдаагүй бусад төрлийн бараа, бүтээгдэхүүнийхээ үнэд нөлөөлсөн. Тэгэхээр хөтөлбөрийн зорилго буюу тухайлсан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах талаас нь харвал үр дүнгээ өгсөн. Гэхдээ том макро зургаар нь харвал эдийн засагт маш том эрсдэл, эмзэг байдлыг бий болгож, сөрөг үр дагаврыг илүүтэйгээр авчирсан байна гэж чуулганд оролцсон судлаачид дүгнэсэн байгаа. Хөтөлбөрт зориулж Монголбанкнаас олгосон мөнгөний дийлэнх нь эргэн төлөгдсөн.

Өдрийн сонин: ОУВС-гаас орж ирдэг мөнгө аль дансанд бичигддэг вэ?

ССГ-ын захирал Д.Ган-Очир:

ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд орж ирж байгаа мөнгийг хоёр ангилна. Нэгдүгээрт, ОУВС-аас өгч байгаа мөнгө. Хоёрдугаарт, ОУВС-ийн хөтөлбөртэй холбоотойгоор доноруудаас олгох хөнгөлөлттэй зээл. ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд зөвхөн ОУВС-аас 435 орчим сая ам.доллар орж ирэх ёстой. Энэ маань төлбөрийн тэнцлийг дэмжих, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилготой. Тэгэхээр шууд Монголбанкны дансанд орж, Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлдэг. Өөр зориулалтаар зарцуулагдахгүй. Харин бусад доноруудаас орж ирж буй мөнгө нь тусгай зориулалттай. Жишээлбэл, төсвийн алдагдлыг хямд, урт хугацаатай хөрөнгөөр санхүүжүүлэх гэх мэт. Тийм учраас Засгийн газрын төсвийн дансанд орж ирдэг. Засгийн газар мөнгөө зарцуулаад явдаг.

Gogo.mn цахим сайт: Ипотекийн зээлийн урьдчилгааг 25 хувь болгох, зээлийн хүүг 7.5 хувь болгож бууруулна гэх мэдээлэл гараад эхэллээ. Энэ үнэн үү, мөн ингэж өөрчлөх боломжтой юу?

Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газар /НУСЗЗГ/-ын захирал А.Энхжин:

Монголбанк ипотекийн хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн онд ОУВС-тай тохирсон

хөтөлбөрийн дагуу Монголбанк 2018 ондоо багтааж, Засгийн газарт хөтөлбөрийг шилжүүлэх ёстой. Үүнтэй холбогдуулж, Сангийн яам, Монголбанк өнгөрсөн онд харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хөтөлбөрийг 2018 оны есдүгээр сардаа багтаад Засгийн газарт шилжүүлэхээр болсон. Үүний дагуу Монголбанкнаас хөтөлбөрийг Засгийн газарт хэрхэн шилжүүлэх, санхүүжилтийн схемийг ямар хэлбэрээр зохион байгуулах гэх зэргээр тодорхой төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Одоогийн байдлаар Монголбанкнаас өөрийн эзэмшилд буй ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөртэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг сар бүр гаргаж байгаа. Мөн Засгийн газраас төсөвт тодорхой хэмжээний эх үүсвэрийг суулгаад, Монголбанктай хамтран ипотекийн зээлийг санхүүжүүлж байна. Энэ онд Монголбанкнаас сар бүр ойролцоогоор 16 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргана. Төсөв дээр 120 тэрбум төгрөг суусан гэхээр сард ойролцоогоор 10 тэрбум төгрөг гэсэн үг. Ингээд тооцохоор сард 26 тэрбум төгрөг гаргаад явах боломжтой. Гэхдээ цаашид ипотекийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Тийм учраас хөтөлбөрийг тогтвортой үргэлжлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар Дэлхийн банкнаас өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газраас хэд хэдэн санал боловсруулаад, судалж үзэж байгаа юм билээ. Үүний нэг нь таны хэлсэнчлэн урьдчилгаа төлбөр, хүүг бууруулах санал юм болов уу гэж ойлгож байна.

Ипотекийн журамд өөрчлөлт орох уу?

НУСЗЗГ-ын захирал А.Энхжин:

Журмаа шинэчлэх талаар Засгийн газрын зүгээс тодорхой ажил хийж байгаа. Эцэслэн батлагдаагүй байгаа.

Төв банк 1.9 тэрбум ам.долларын алдагдалтай байгаа талаар дурдлаа. Энэ алдагдал юунаас үүссэн бэ, алдагдлыг бууруулах талаар ямар төлөвлөгөө байна вэ?

ССГ-ын захирал Д.Ган-Очир:

Миний ярьсан тоо нь Монголбанкны алдагдал бус гадаад өр юм. Монголбанкны гадаад өрийг бид бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн жил Монголбанкны гадаад валютын нөөц сөрөг утгатай байна, яагаад гэвэл Монголбанк гадаад өглөгтэй байгаа учраас гэдэг асуудал яригдсан. Өөрөөр хэлбэл, Монголбанк Хятадын Ардын Банк хооронд нийт 15 тэрбум юанийн своп хэлцэл байгуулсан. Өнгөрсөн жилүүдийн бодлогын зардал нь

юу байсан бэ гэхээр үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд гаргасан мөнгөний нийлүүлэлт нь валютын ханшийн сулрах дарамтыг нэмэгдүүлсэн. Монголбанкнаас ханшийн тогтвортой байдлыг хангах зорилгоор маш их интервенц хийсэн. Интервенц хийхдээ Хятадын Ардын банкт байгуулсан своп хэлцлийнхээ мөнгөн хөрөнгөөс авч, ашигласан байдаг. Тэгэхээр свопын ашиглалттай холбоотойгоор Монголбанкны гадаад өглөг өссөн байгаа. Харин Монголбанкны алдагдлын хувьд 2017 оны эцсийн байдлаар Монголбанк сүүлийн 5 жилд анх удаа ашигтай ажилласан. Үүний дараагаар Монголбанкны нийт хуримтлагдсан алдагдал 2.8 их наяд төгрөг болж, буурсан. Цаашдаа алдагдлыг хэрхэн нөхөх талаар Монголбанк тодорхой төлөвлөгөө боловсруулаад, ажиллаж байна. Алдагдлыг цаг хугацааны туршид бууруулах боломжтой гэж үзэж байгаа.

Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Шинэ хуулийн давуу тал юу вэ. Монголбанкны хараат бус байдлыг нэмэгдүүлэхэд дэвшилттэй заалтууд орж чадсан уу?

Хууль эрх зүйн газар /ХЭЗГ/-ын захирал Б.Ганбат:

Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өмнөх хуулиасаа нэлээд сайжирсан. Өмнөх хуулиа дордуулсан зүйл байхгүй гэдгийг цохож хэлье. Төв банкны тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбоотойгоор улстөржсөн шинжтэй мэдээллүүд тодорхой хэмжээнд гарч байгаа. Банкны салбар итгэлцэл дээр тогтдог. Тэгэхээр энэ салбарын асуудлыг улстөржүүлэх ямар ч шаардлагагүй. Төв банкны хараат бус байдлын тухайд Монголбанк бодлогын шийдвэрээ мөнгөний бодлогын хороо гэх бүтцээрээ дамжуулж гаргана. Хорооноос тогтоол гарна. Тогтоолыг Монголбанкны Ерөнхийлөгч гарын үсэг зурж, баталгаажуулахаар зохицуулалт орсон. Тэгэхээр нэг субъектээс хамааралтайгаар бодлогын шийдвэр гарч байсан өмнөх хуулийн практикийг халж, мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага бүхий 7 гишүүнээс бүрдсэн мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, хамтын шийдвэр, хамтын удирдлагын зарчимд шилжиж байна. Энэ агуулгаараа Төв банкны хараат бус байдал, хариуцлагатай байдал нэмэгдсэн гэж хараасай гэж хүсч байна. Иргэд, олон нийт, улстөрчдийн зүгээс төв банкны өмнөх 4 жилийн алдааны талаар их ярьж, хэлэлцүүлэг өрнүүлдэг. Энэ алдааг та бүхэн төв банкны хараат бус байдлыг илтгэх нэг хэмжүүр болох Засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх зарчим

алдагдсаны үр дүн гэж ойлгож болно. Тэгэхээр шинэ хуулийн зохицуулалтаар Монголбанк Засгийн газартай улирлын шинж чанартай зээл өгөх асуудлаар харьцаж болно. Мөн Засгийн газрын бондыг худалдах, худалдан авахтай холбоотой асуудлаар харьцаж болно. Харин Засгийн газрын төсвийн шинж чанартай аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхгүй. Энэ зохицуулалтынхаа хүрээнд өмнөх хуулиасаа хэд дахин илүү болсон гэдгийг онцольё.

News.mn цахим сайт: Банкны тухай хуулийн хүрээнд арилжааны банкууд охин компанитай байхыг хориглосон. Тэгэхээр банк бус санхүүгийн байгууллагуудыг ихэвчлэн банкууд байгуулж, мөнгө хүүлэх үйл ажиллагаа хийж байна гэх хардлага байдаг. Хуулиар энэ асуудал зохицуулагдаж байгаа юу?

ХЭЗГ-ын захирал Б.Ганбат:

Монголбанкнаас хуулийн төслөө УИХ-ын гишүүнээр дамжуулж өргөн бариулсан. Өргөн барьсан гишүүн анхны хуулийн төсөлдөө охин компани байгуулахыг хориглох, хязгаарлах хуулийн зохицуулалт тусгаагүй байсан. Хуулийн төслийг УИХ-ын байнгын хороо, чуулганаар хэлэлцүүлэх явцад гишүүдээс гаргасан саналын дагуу банкны хараат болон охин компани байгуулахтай холбоотой асуудлыг хөндсөн. Яагаад гэвэл анх өргөн барьсан хуулийн төслөөрөө Банкны тухай хуулийн 6.2 дахь хэсэгт заасан зохицуулалттай холбогдсон зүйл заалтыг хөндсөн байсан учраас охин буюу хараат компани байгуулахтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгөх боломжтой болсон. Тэгэхээр шинээр батлагдсан хуулийн дагуу банк доороо охин буюу хараат компани байгуулах боломжгүй. Харин тухайн банкныг байгуулсан толгой компани нь охин буюу хараат компаниа байгуулаад явах бололцоотой. Тэгэхээр банк бол банкны мэргэжлийн үйл ажиллагаа л явуулна. Үүнээс бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр доороо охин буюу хараат компани байгуулж болохгүй. Энэ зохицуулалт 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Тэр хүртэлх хугацаанд одоо байгуулагдсан байгаа банкны охин болон хараат компаниуд тодорхой зохицуулалтаа хийх боломжтой.

Банк бус санхүүгийн байгууллагууд банкуудын дор байдаг гэх яриа бий энэ хуулинд хамаатай юу?

ХЭЗГ-ын захирал Б.Ганбат:

Банк бус санхүүгийн байгууллага тусдаа хуультай. Банкны хуулиар банк хараат буюу охин компани байгуулахыг хориглож байгаа.

1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2017.12 сар




МУ-д орсон ШХО, 2017.III улиралд

459 сая \$ /Цэвэр дүн/




Үүнээс:

Канад 285 сая \$
 Люксембург 155 сая \$
 БНХАУ 65 сая \$
 Бусад 197 сая \$



2. Гадаад хөрөнгө оруулалтын позицын статистик, 2017.III улирал

Гадаад актив (4,620.5 сая \$)




Гадаад пассив (35,465.5 сая \$)



ПОЗИЦ	(30,845.0)
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(16,283.6)
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(4,262.1)
Санхүүгийн дериватив (цэвэр)	0.5
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(11,927.0)
Нөөц актив	1627.1

3. Гадаад өрийн статистик, 2017.III улирал



Улаанбаатар хотын инфляци 12 дугаар сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2017 оны 12 дугаар сард** улсын хэмжээнд **6.4%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **7.2%-д** хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн



Улаанбаатар хот
инфляци
/жилийн/

МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

“ Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд заасан ”
өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараахь
чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний бодлогыг
боловсруулж, хэрэгжүүлнэ



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн
мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10
дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн
барина



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татна
Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх,



хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр
эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах
ажлыг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг
Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын
хүсэлтээр өөр дээрээ байршуулж, гүйлгээг хийнэ



Засгийн газрын хүсэлтээр Засгийн газрын үнэт
цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл
ажиллагаа эрхэлнэ



Банк болон хуульд тугайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтолцооны найдвартай байдлыг
бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл
банкинд олгоно



Үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм,
журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл
ажиллагаанд хяналт тавина

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь
тухайн банкны харилцах дансаар дамжуулан
гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний
төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад
валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн
гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангана



Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй
адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж
авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг
хэрэглэгчийг хамгаалах хяналттай хослуулна



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11
зарчмыг нэвтрүүлнэ



Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг
дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ




Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк,
санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан
сэргийлэх зорилгоор тус бодлогыг боловсруулна



Макро зохистой бодлогыг заавал байлгах нөөц зэрэг
хэрэгслүүдээс ашиглан хэрэгжүүлнэ



ВАЛЮТЫН ХАНШ ГАДААД ВАЛЮТЫН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТЭЭС ХАМААРДАГ

Уншигч авхай таныг шинээр нээж буй энэхүү булангаар Монголбанкны өдөр тутмын үйл ажиллагаатай танилцахыг урьж байна. Монгол Улсын тусгаар тогтнолын илэрхийлэл болсон төгрөгийн тогтвортой байдлын төлөө хэрхэн бодлогын арга хэмжээнүүд хэрэгждэг болохыг Монголбанкны ажилтнуудтай хийх өдрийн сурвалжлагаар сонирхоно уу. Анхны оролцогчоороо бид Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхзулын ажлын нэг өдрийг сонирхуулж байна. *Монголбанк: 2018.01.23*

Б.Мөнхзулын өдөр тутмын ажил юунаас эхэлдэг вэ?

Өглөө ажилдаа ирсэн даруйдаа зах зээлд нөлөөлж болохуйц мэдээ, мэдээллүүд юу байна, гадаад болон дотоод зах зээл дээр гарсан мэдээллүүд, олон улсын хөрөнгийн зах зээл дэх мэдээллүүд, тэр дундаа Монголтой холбоотой мэдээллүүдийг олж уншдаг. Ялангуяа, Монгол Улсад валютын зах зээл, валютын ханш нь барууны хөрөнгийн зах зээлтэй адилгаж болохоор мэдээлэлд маш хурдан хариу үйлдэл үзүүлдэг. Тийм учраас энэ зах зээлд ажиллаж, анализ шинжилгээ хийж байгаа хүний хувьд мэдээллүүдийг маш шуурхай авч, дүн шинжилгээ хийж байх шаардлагатай. Үүнээс гадна бусад статистик мэдээллүүдийг тухай бүрт нь шуурхай авдаг. Эндээс л миний ажил эхэлдэг дээ.

Тэгвэл ойрын үеийн санхүүгийн зах зээлийн сониноос хуваалцана уу, төгрөгт үзүүлэх нөлөө ямар байх төлөв ажиглагдаж байна вэ?

Ойрын хугацаанд Монгол Улсын эдийн засаг, тэр дундаа гадаад секторын үзүүлэлтүүд нэлээд эерэг үзүүлэлттэй гарч байгаа. Хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын зээлжих зэрэглэл өслөө. Энэ нь Монгол Улсын экспортод гаргадаг эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, ДНБ-ий өсөлт нэмэгдсэн, ойрын хугацааны гадаад өрийн дарамт буурсан зэрэгтэй холбоотой гэсэн байгаа. Тэгэхээр гадаад зах зээл Монгол Улсыг эерэг өнцгөөр харж эхэлж байна гэсэн дохиог энэ мэдээллээс авч болно. Цаашлаад Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж буй энэ үед зээлжих зэрэглэл өсөх нь Монгол Улс руу орж

ирэх валютын урсгалыг нэмэгдүүлж болзошгүй. Зах зээлд ийм хүлээлт бий болоод эхлэхээр банкууд, томоохон аж ахуйн нэгжүүд, харилцагчдын валют худалдаж авах, зарах үйл ажиллагаанд хүлээлт тусгалаа олдог.

Гэтэл ханш чангарч сулрах нь Монголбанкнаас хамаатай гэсэн ойлголтыг дашрамд залруулмаар санагдаж байна. Мөнхзул маань валютын зах зээлтэй биднийг бодвол ойр ажилладагийн хувьд үүнд тайлбар өгвөл ямар вэ?

-Валют гэдэг маань нэг л төрлийн бараа. Тэгэхээр Монголбанк мөнгөний бодлогоороо дамжуулж, зах зээл дээр байгаа бүх төрлийн барааны үнэд нөлөөлөх боломжтой. Зах зээлд байгаа энэ олон бараануудаас зөвхөн нэг төрлийн барааны үнийг гол зорилтоо болгоод бусдыг нь хайхрахгүй орхиж



болохгүй. Энгийнээр төв банк зах зээлд байгаа нэг бараанд хэдэн төгрөг байх ёстой вэ гэдгийг л зохицуулж чадна. Бараа, үйлчилгээг нь харин компаниуд, иргэд үйлдвэрлэдэг. Эндээс үзвэл валютын ханшийг тодорхойлох гол зүйл болох валютын нийлүүлэлтийн асуудал бол нийт Монголчууд бидэнд хамааралтай. Монголчууд чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд зарж байж экспортын орлого маань нэмэгдэж, төрөлжинө. Мөнгө зүгээр ургачихдаггүйгээс хойш өнөөдөр бид олон төрлийн бараа, үйлчилгээг дэлхийн зах зээлд нийлүүлж валютын тогтвортой орлого олж чадахгүй л бол төгрөгийн ханш түүхий эдийн үнийг дагаж “галзуу хулгана” шиг огцом савладаг явдал буурахгүй байх. Нөгөө талаас төв банкнаас хэсэг хугацаанд валютын нөөцөөсөө худалдаж ханшийг тогтмол барьж болно. Гэвч валютын нөөц дуусч ам.доллар нүдний гэм болохоор ханш ч богино хугацаанд огцом өсдөг. 1990 онд дэлгүүрийн лангуунд бараа байхгүй байхад юмны үнэ яаж өссөн билээ, валютын ханш дээр ч зүй тогтол нь яг л адилхан. Харин төв банк валютын ханшийг биш үнийн тогтвортой байдлыг онилно гэдэг нь зөвхөн өргөн хэрэглээний хэдхэн барааны тухай биш импортын бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах агуулга ч цаана нь багтаж байгаа. Би 2014 онд валютын ханш инфляцид яаж нөлөөлж байна вэ гэдэг судалгаа хийж байсан юм.

Манай өргөн хэрэглээний барааны сагсны 30-40 хувь нь импортын бараа байдаг бөгөөд төгрөгийн ханш 10 хувиар сулрахад, зургаан сарын дотор инфляци 4 нэгж хувиар өсөх нөлөө үзүүлдэг гэсэн үр дүн гарсан. Эндээс харахаар үнийг тогтвортой байлгахдаа валютын ханшийг авч үзэхээс өөр аргагүй. Иймээс төв банк инфляцийг нам тогтвортой байлгах нь валютын ханшийг тогтвортой байлгахад өргөн агуулгатай ойлголт болж байгаа юм. Албан ханшийн тухай энэ ташрамд тайлбарлавал ямар вэ?

Тэгэлгүй яахав. Олон нийтийн дунд энэ талаар төдий л сайн ойлголтгүй байх нь ажиглагддаг.

-Монголбанк албан ханш нь тухайн өдөр зах зээл дээр арилжаалагдаж байгаа авах, зарах бүх арилжааны жигнэсэн дундаж ханш. Тухайн өдөр ам.доллар зах зээлд дунджаар ийм ханшаар арилжигдсан тул нэг долларын төгрөгөөрх үнэ цэнийг 2422 төгрөг 30 мөнгө гэж үзээрэй гэсэн мэдээллийг хүмүүст хүргэж байгаа юм (Сурв. Ярилцлага авсан өдрийн албан ханш). Энэ мэдээллийг ашиглаад аж ахуйн нэгжүүд валютаарх хөрөнгө эсвэл өр төлбөрөө тайландаа бүртгэх, гаалийн татвар төлж байгаа хүмүүс хэдэн төгрөгийн татвар төлөх вэ, шүүх дээр маргаантай байгаа хүмүүс валютын өглөг, авлагаа яаж тооцох вэ гэх зэрэгт ашиглана. Монголбанк ханшийг зарлахгүй бол хүмүүс банк бүрийн ялгаатай ханшаар өөр өөр

тайлан гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргахдаа янз бүрээр гаргах гээд их түвэгтэй байдал үүснэ. Эдгээрийг зохицуулах зорилгоор хуулинд Монголбанкны зарласан ханшийг нягтлан бодох бүртгэл, гааль, шүүхийн зорилгоор ашиглана гэж заасан байгаа. Тэгэхээр Монголбанк ханш тогтоож байгаа биш, банкуудын арилжааны бүх тайлан, мэдээг авч байгаагийн хувьд валют арилжааны ханшийг дунджилж хэмжээд, албан ёсоор зарлаж байна гэсэн үг.

Мөн үүнээс гадна ханшийн хөдөлгөөнд Монголбанкны явуулж байгаа бодлого, эсвэл Засгийн газрын бодлого шийдвэр хэрхэн нөлөөлдөг вэ?

-Монгол Улс маань байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалтай. Улирлын нөлөөлөл эдийн засагт маш өндөр. Импортоор авч байгаа бараа, бүтээгдэхүүн нь харьцангуй олон төрөл. Гэтэл экспортын орлого нь хэдхэн салбараас хамааралтай, том дүнтэй байдаг. Үүнээс болоод валютын эрэлт, нийлүүлэлт нь хугацааны хувьд зөрүүтэй нөхцөл байдал үүссэнээс болоод зах зээл дээр ханш огцом хэлбэлзэх нөхцөл байдал бий болбол Монголбанк тэрийг зохицуулж оролцох шаардлага гардаг. Яагаад гэвэл иргэд, компаниудад бодлогын байгууллагууд шиг зах зээлийн мэдээлэл цогцоороо байдаггүй тул үнэ, ханшийг хөдөлгөөн үүсэх үед энэ нь түр зуурын шинжтэй юу

эсвэл удаан үргэлжлэх үү гэдгийг мэддэггүй. Улмаар үнэ ханш огцом хэлбэлзэж эхлэхэд зах зээлд оролцогсод сандарч, буруу шийдвэр гаргадаг. Зах зээлийн жижиг доргион цаашлаад банк, санхүүгийн салбарыг цочроох, хямраах хүртэл эрсдэл дагуулах магадлалтай. Энэ эрсдэлийг хаах зорилгоор Монголбанк валютын зах зээлд оролцдог. Ер нь банк, санхүүгийн салбар чинь өөрөө итгэл дээр тогтдог салбар болохоор, буруу мэдээлэл хүчтэй тархах нь их хор уршиг дагуулдаг. Харин урт хугацаанд валютын тогтвортой нийлүүлэлтийг бүрдүүлэхэд Засгийн газрын бодого илүү чухал. Монгол улс маань арвин баялаг нөөц, түүхий эдтэй орон болохоор гадны хөрөнгө оруулагчид үүнийг боловсруулж бүтээгдэхүүн болгоод дэлхийн зах зээлд зараад ашиг олох сонирхол их байдаг. Эдгээр хүмүүсийг татах, оруулсан хөрөнгөө салхинд хийсгэчихгүй гэсэн итгэл төрүүлэх хууль эрх зүйн орчин, төрийн тогтвортой бодлого, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж чадвал долларын ханш өндөр байна гэж биш гадны зах зээлд бараагаа худалдах гэхээр энэ төгрөгийн ханш чинь их өндөр байна гэж гомдоллодог болох байх. /Инээв/

-Тийм учраас шийдвэр гаргагчид мэдээлэлд бодитой хандах үүрэгтэй гэж боддог. За, яг өнөөдөр хийж байгаа ажлынхаа талаар сонирхуулаач?

-Валютын ханшид юу нөлөөлж байна вэ гэдэг судалгааг би хэлтсийнхэнтэйгээ хамтран хийж байна. Тэр дундаа би яг ханшийн зохистой, тэнцвэрт түвшинг ямар хүчин зүйлс тодорхойлж байна, тэр түвшин хаана байна гэдгийг судалж байгаа. Төв банк зах зээлийн суурь хүчин зүйлтэйгээ нийцтэй,



урт хугацаандаа эдийн засагт хүртээмжтэй, өгөөжтэй байдлаар ханшийнхаа бодлогыг явуулахад төгрөгийн ханш өнөөдөр тэнцвэрт түвшиндээ байна уу гэдгийг мэдэх нь чухал. Өнөөдөр 1 ам.доллар 2422.30 төгрөг байгаа нь жишиж хэлбэл багшийн авсан шалгалтын л дүн. "Гурав" авах хэмжээний мэдлэгтэй хүүхэд шалгалтанд азаар "тав" авчих тохиолдол гардаг шүү дээ. Ханш тэнцвэрээсээ хэт өндөр байвал тодорхой хугацааны дараа буурч, бага байвал өснө. Дээрх жишээнээс үзвэл тэр хүүхдийн 3 авах хэмжээний мэдлэг, чадварыг нь тэнцвэрт ханш гэж тодорхойлж байгаа. Ханш тэнцвэрт түвшнээсээ ялгаатай удаан явах тусам тэнцвэрт түвшиндээ очихдоо эдийн засагтаа их хэмжээний сөрөг нөлөө дагуулдаг болох нь судалгаагаар батлагдсан байдаг. Валютын ханшийн талаар судалсан судалгаанууд Монголд ч цөөнгүй бий. Гэхдээ бидний судалгааны онцлог гэвэл ханшийн хөдөлгөөнийг тайлбарлах чадварыг сайжруулахад микро түвшний үзүүлэлтүүдийг ашиглаж байгаа. Ингэснээр бидний судалгаа ханшийн хөдөлгөөнийг илүү сайн тайлбарлах байх гэж бодож байгаа.

-Танай хэлтэс яг нэг үеийн, харьцангуй залуу хамт олон юм аа. Хэлтсийнхээ ажлыг товч тайлбарлаач?

-Манай хэлтэс Монголбанкнаас зах зээлтэй харьцаж, зах зээлийн үйл ажиллагааг явуулдаг хэлтэс. Төв банкны үнэт цаасыг банкуудад арилжаалах, валютын интервенц, банкуудаас хадгаламж татах, банкуудад овернайт зээл олгох, репо хэлцэл хийх, ЗГҮЦ-ны анхдагч арилжаа манай хэлтэс дээр явагддаг. Үүнээс гадна зах зээлийн анализ, шинжилгээнүүдийг хийгээд явж байдаг. Ийм нэгж юм. Монголбанкны мөнгөний бодлогыг гардаж хэрэгжүүлдэг фронт оффис гэж болно. Төв банкийг хүн гэвэл Мөнгөний бодогын газар уураг тархи нь харин манай хэлтэс гар, хөл нь юм уу даа. Энэ дашрамд миний ажилд зааж, зөвлөж, үлгэр жишээ үзүүлж байсан, гар нийлж ажилладаг ажлын хамт олондоо их баярлаж явдгаа хэлье.

-Та нарын ажил их сонирхолтой санагдаж байна. Бас их хариуцлагатай ажил байна. Чамд болоод танай хамт олонд ажлын амжилт хүсье. Ажлын цагаасаа зориулсанд баярлалаа.



ӨГӨӨДЭЙ ХААНЫ ҮЕИЙН МӨНГӨН ЗООС

Чингис хаан ба түүний залгамжлагчид хоёр зуу гаруй төрлийн зоос дэлдүүлж, эргэлтэд оруулсан нь эдүгээ мэдэгдээд байна. Монголын эзэнт гүрний үед хамаарах хамгийн эртний зоос нь 1221-1227 оны Чингис хааны зоос, хожуу үеийнх нь 1447 оны Шахрух хааны зоос юм. Тэдгээрээс Өгөөдэй хааны зоосыг танд танилцуулж байна.



Өгөөдэй хааны мөнгөн зоос

Зураг 1 1233 он Сарава хот

Жин: 1.8 гр

Голч: 1.9 см

Нүүр: "Аугаа их хаан" гэж бичсэн. Нуман тамгатай.

Ар тал: "Аллахаас өөр бурхан үгүй. Мухаммед бол Аллахын элч" гэж арабаар бичсэн.



Өгөөдэй хааны мөнгөн зоос

Зураг 2 1227-1241 он Имиль хот

Жин: 1.8 гр

Голч: 2.1 см

Нүүр тал "Тэнгэрийн хүчин дор" гэж арабаар бичсэн. Дэгрээ тамгатай.

Ар тал: "Аллахаас өөр бурхан үгүй. Мухаммед бол Аллахын элч" гэж арабаар бичсэн.



Өгөөдэй хааны мөнгөн зоос

1227-1241 он

Жин: 3.1 гр

Голч: 1.9 гр

Нүүр тал: "Аллах" гэж арабаар бичсэн. Дэгрээ тамгатай.

ар тал: "Их Орд" гэж арабаар бичсэн.



Дөргөнө хатны үеийн мөнгөн зоос

1241-1246 он

Тбилис хот

Жин: 2.8 гр, голч: 1.9 см

Нүүр тал: "Их Монгол Улсын хан" гэж арабаар бичсэн.

Ар тал: Морин дээрээ эргэж хараад нум сум харваж буй морьтон дүрсэлсэн. Морьтон шувуу болон анч нохой дагуулсан ажээ.

Т.БАТБАЯР: ЗЭЭЛИЙН ХҮҮ, ХАНШИЙГ ХҮЧЭЭР ТОГТООХ БОЛЧИМГҮЙ АЛХАМ БАЙЖ БОЛОХГҮЙ

Капитал банкны ТУЗ-ийн дарга Т.Батбаяртай ярилцлаа. Тэрээр 1960-1990 он хүртэл тухайн үеийн Улсын банкинд зээлийн байцаагчаас эхлэн орлогч дарга, нэгдүгээр орлогч дарга хүртлээ дэвшин ажилласан, Монголбанкны ахмад ажилтан юм.



БОЛОВСРОЛ:

1961: Санхүүгийн техникум —
Зээлийн нятлан бодогч

1969: ЗХУ-ын Улс Ардын аж ахуйн
дээд сургууль-Санхүү, зээлийн эдийн
засагч

1977: ЗХУ-ын Нийгмийн ухааны
академи-Улс төрийн дээд мэргэжил

1994: Москвагийн санхүү, Эдийн
засгийн дээд сургууль-Эдийн
засгийн ухааны доктор

АЖЛЫН ТУРШЛАГА:

1961-1964: Дундговь аймгийн
банкнд зээлийн ахлах байцаагч

1964-1974: Улсын банкинд зээлийн
байцаагч, ахлах байцаагч, зээлийн
ахлах мэргэжилтэн

1972-1975: Улсын банкинд Хөрөнгө
оруулалт, санхүүжилтийн газарт
хэлтсийн дарга

1977-1979: Намын төв хорооны
Эдийн засгийн хэлтэст зааварлагч

1979-1990: Улсын банкинд Орлогч
дарга, 1-р орлогч дарга

1990-2002: Москвагийн Олон улсын
банкнд газрын дарга, орлогч дарга,
зөвлөх

2002-2006: Капитал Банкнд зөвлөх

2006 оноос хойш: Капитал Банкны
ТУЗ-ийн дарга

Монгол Улс сүүлийн 20 гаруй жилд эдийн засгийг нарийн төлөвлөгөө, бодлоготойгоор хөгжүүлэх ёстой байсан гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?

-Төлөвлөгөөт эдийн засгийн үед манай улс, хоршооллын өмчид суурилсан эдийн засагтай байсан тул улс төр, нийгэм эдийн засгийн бүх хүрээг хамарсан бодлогыг төр нэг гарт төвлөрүүлэн төвлөрсөн төлөвлөгөөнд суурилсан нэгдсэн бодлоготойгоор зохицуулж байсан учир түүнийг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо хэмээн нэрлэж байлаа. Нэгдсэн төлөвлөгөө нийгмийн бодлогыг бүтээх хүчин зүйлс тухайлбал, ажиллах хүчний нөөц, материал түүхий эдийн хангамж, үндсэн хөрөнгө техник технологийн боломжийг улсын хэмжээгээр нэгтгэн тооцоолж, түүхий эдээ санхүүгийн ямар эх үүсвэрээр нөхөх вэ? гэдгийг тэнцвэржүүлэн балансжуулж хэдий хугацаанд барьж байгуулах гэдгийг нарийвчлан тооцоолж, төлөвлөдөг. Түүнийг яам, газрууд нь хэрэгжүүлж хяналт тавьдаг байлаа. Үнэхээр Улс нийгмийн өмчид суурилсан аж ахуйн нэгжийг хөгжүүлэх үүнээс өөр арга боломж байгаагүй. Нэгэнт зах зээлийн харилцаанд шилжсэн өнөөгийн нөхцөлд улс

орны хэмжээгээр нэгдсэн төлөвлөгөө бодлого, төлөвлөж хэрэгжүүлэх боломж нөхцөл тун хомс. Учир нь, нэгэнт тогтсон хувь хүний юм уу, хувийн өмчид суурилсан ХХК, ХК-ийн өмчийг төр үйл ажиллагаанд нь оролцож, төлөвлөж, удирдан зохицуулах боломж байхгүй. Харин төрийн мэдлийн өмч хөрөнгийг барьж байгуулах түүнд хяналт тавих, улсын төсвийн болон зээлийн гэх мэт төр өөрийн мэдлийн хөрөнгийг бүтээн байгуулахад, шинээр баялаг бүтээхэд зарцуулах хугацаа, өртөг, зардлыг тооцоолж энэ бүх ажлыг төлөвлөхөд өмнөх нийгмийн туршлагыг ашиглах боломж байгаа юм.

Монгол шиг гадаад зах зээлээс хамааралтай, хуримтлал үүсгэдэггүй улсад эдийн засгийн дархлаагаа нэмэгдүүлэх гол арга, механизм нь таны бодлоор юу байх бол?

-Эдийн засгийн дархлаагаа сайжруулахад юу чухам саад болж байна вэ гэхээр төр засгийн бодлоготой зарим талаар холбоотой. Эдийн засгийн үе шаттай мөчлөг бүхий хямрал болгонд өртөж байгаа нь ердөө уул уурхайд найдаж түүнд түшиглэсэн эдийн засагтай болсных. Улс төрийн тогтворгүй байдал, төр засгийн татварын

бодлого, татварын ойлгомжгүй байдал нь олон улсын стандартаас хоцрогдох байдалтай байгаа нь гадны хөрөнгө оруулагчдыг Монголд орж ирэхээс хойш суух, жийрхэх хандлагыг бий болгож байна. Иймд зөвхөн уул уурхай гэхгүйгээр нэн тэргүүнд уламжлалт мал аж ахуйгаа түшиглэж, эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг үе шаттайгаар хөгжүүлэхэд төр засгаас онцгой анхаарал хандуулж, томоохон төсөл хэрэгжүүлж чадвал эдийн засгийн дархлааг сайжруулахад томоохон алхам болно.

Уул уурхайгаас өөр салбараа хөгжүүлж, эдийн засгаа солонгоруулж, олон тулгууртай болгоно гэсэн өнөөг хүртэл хийж чадаагүй л байна. Энэ тал дээр таны бодлыг сонсоё?

-Ганцхан уул уурхайн бодлогыг хөгжүүлэх бус наад зах нь 60 гаруй сая толгой малынхаа ашиг шимийг ашиглах жижиг үйлдвэрүүдийг тухайн орон нутгийн онцлогийг харгалзан аймаг, сумд дунд барьж байгуулах. Говь, Буян, Алтай зэрэг ноос, ноолуур боловсруулдаг үйлдвэрүүдийн туршлага, технологийг түшиглээд тэднээс авдаг татвараа багасгах замаар буюу гадаадаас авч байгаа хөнгөлөлттэй зээл, тусламжаас зохих хэмжээгээр олгож зарим аймгуудад тухайн үйлдвэрийн салбар нэгжийг нь байгуулж болох юм. Эдгээр үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргах хаана үнэ цэнэтэй байгаа түүнийг гадаад хэргийн яам, гадаад орнуудад суугаа элчин сайдын яамдын судалгааг үндэслэн экспортод гаргавал улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхээс гадна өөрийн эх орны жижиг үйлдвэрлэгчдэд хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг

нь нийлүүлэх гэх мэт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх өргөн боломж байгаа. Гагцхүү санаачилга гаргаж холбогдох яам нь МҮХАҮТ-тай хамтарч ажиллавал үр дүнд хүрэх нь тодорхой. Шүүмжлэлээс айж болгоомжлохгүйгээр улс оронд өгөөжтэй бодит ажлыг хийх талаар зориглох цаг нэгэнт болсон. Мөн аялал жуулчлал, газар тариалан, гахай, шувууны төрөлжсөн аж ахуй зөгий, загасны аж ахуй зэргийг байгуулах замаар ажиллавал дан ганц уул уурхайн эрдэс баялагт түшиглэж түүнд найдвар тавихгүйгээр эдийн засгаа солонгоруулах боломжтой.

Бодлогын зорилт, эдийн засагт дутагдаж буй мөнгийг нийлүүлэхэд төв банк ямар бодлого баримталж ажилладаг байсан бэ?

-1990-ээд оноос өмнө Банкны бодлого нь улс орны эдийн засгийн үндсэн бүрэлдэхүүний гол хэсэг болсон мөнгө, зээл, хөрөнгө оруулалт, төлбөр тооцоо гэсэн банкны үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байлаа. Эдийн засагт эргэлдэж байгаа мөнгөн гүйлгээний маш бага буюу дөнгөж 10 хүрэхгүй хувийг л улсын төсвийн орлого зарлага эзэлдгээс гадна гадаадын зээл тусламжийн хөрөнгө, банкны гүйлгээнд их биш хувьтай байсан. Өмнөх нийгмийн үед гүйлгээнд гаргагдаж байгаа нэг ч төгрөг банкны хяналтаас гадуур явагдахгүй. Мөнгөн гүйлгээг кассын, зээлийн гэсэн төлөвлөгөө улирал бүр зохиож СНЗ-д оруулж батлуулахын тулд төв орон нутгийн үйлдвэр аж ахуйн байгууллага холбогдох яамдаас энэ төлөвлөгөөг авч нэгтгэн хянаж урьд оны мөн үетэй зэрэгцүүлэн хянаж өсөлт бууралтын шалтгааныг зохих тайлбар дүгнэлтийн хамт

хийж хүргүүлэн хурлаар хэлэлцүүлэн батлуулж мөрддөг байлаа. Жил, таван жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ямар нэгэн барилга объект баригдах эрх байгаагүй. Төв орон нутгийн банкны байгууллага төлөвлөгөөнд тусгагдан баригдаж буй барилга объект нэг бүрийг их бага гэхгүйгээр газар дээр нь очиж хэмжин шалгалт хийж зураг, төсөвтэй нь харьцуулж шалгасны дараагаар санхүүжилтийг хийдэг байлаа. Тухайн үед санхүүжилт нь хийгдэхээс урьд нь төлөвлөх, хянах, газар дээр хянаж шалгах гэх гээд нүсэр их ажил хийгдэж байсан юм. Энэ нь тэр үедээ хөрөнгө мөнгийг үр ашигтайгаар зөв зарцуулахад төр засгаас их анхаарсан нь маш зөв юм шиг байсан ч аж ахуйн дотоод ажилд хэт оролцож, аж ахуйн удирдлагын идэвх санаачлагыг үнэхээр боогдуулдаг байлаа. Одоо урьдынх шиг бүх байгууллага ганцхан улсын банкинд данстай түүгээрээ үйлчлүүлдэг харилцаа нь хувийн хэвшлийн зах зээлийн харилцаанд шилжсэн. Арилжааны банкууд иргэд, аж ахуйн нэгжүүдээс хадгаламж, харилцах татахын тулд өрсөлдөж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө зээл олгож байна.

Монгол дахь арилжааны банкны сүүлийн 20 гаруй жилийн хөгжлийн төвшинг та хэрхэн үнэлэх вэ?

-Арилжааны банкны сүүлийн 20 гаруй жилийн хөгжлийн төвшинг хувь хүнийхээ хувьд авч үзвэл улсын хэмжээнд бүх аймаг, сумдад хэд хэдэн арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Тэр хэрээр банкаар үйлчлүүлж, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ авдаггүй, зээлгүй айл өрх, иргэд аж ахуйн нэгж, байгууллага, албан газар байхгүй болсон байна. Ингэж

банкны салбарын үйлчилгээний цар хүрээ өргөжиж хүн ардад үйлчлэх банкны үйл ажиллагааны хүртээмж хангалтай хэмжээнд хүрч өссөн нь яах аргагүй банкны хөгжлийг илтгэх нэг томоохон үзүүлэлт юм. Банкны байгууллага ийнхүү иргэд аж ахуйн нэгжүүдэд хүрч ажиллаж, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр улс оны эдийн засаг нийгмийн хөгжилд ихээхэн хувь оруулж байдаг. Цаашид төр засгийн авч явуулж байгаа бодлогыг амьдралд тууштай хэрэгжүүлэхэд банкны салбар нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг улам нэмэгдэх нь тодорхой.

Таны бодлоор зээлийн хүүг бууруулахад төр ямар бодлого баримтлах ёстой юм бол?

-Зээлийн хүүг бууруулах үндсэн гол нөхцөл юу байж болох вэ? гэвэл юуны урьд зээлийн хүүгийн өндөр байгаа шалтгааныг олох нь юу, юунаас чухал шүү дээ. Юун түрүүнд эдийн засгийн үндсэн суурь гэгдэж буй үнэ, төгрөгийн ханш, хүүг албан хүчээр тогтоох гэсэн болчимгүй яриа байж болохгүй. Зээлийн хүү өндөр байгаа гол шалтгаан гэвэл гадаадын хөрөнгө оруулалт зогсонги байдалд орж, гаднаас орж ирэх мөнгөний урсгалд хомстол үүссэнээс мөнгө ховордож байна. Мөн бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх, тогтвортой хуулийн орчин зүй ёсоор үгүйлэгдэж байгаагийн илрэл. Уул шугамдаа мөнгөний нийлүүлэлт өсч эдийн засаг тэлж хувийн хэвшил дэвжиж ард иргэдийн орлого хадгаламжийн хуримтлал өсч нэмэгдэх хэмжээгээр зээлийн хүү аажмаар буурах ёстой. Зээлийн хүү өндөр байгаа нь маргаангүй үнэн. Манайд зээлийн эрэлт байнга өсч нийлүүлэлт нь, тасалдал ихтэй байна. Энэ нь банкууд эдийн засгийн өндөр

өсөлттэй үед зохих хуримтлал бий болгоогүйтэй холбоотой. Нөгөөтээгүүр хадгаламжийн хүүнээс зээлийн хүү нь шууд шалтгаалдаг. Зах зээлийн нийгэмд шилжсэн эхний үед арилжааны банкууд аж ахуйн нэгжүүдэд жилийн 100 гаруй хувийн хүүтэй зээл олгодог байсныг одоогийн байгаа 20 орчим хувийн зээлийн хүү нь өндөр бус уу гэж та асууж байх шиг байна. Энэ нь тэр үед инфляц 325 хүрч үнэ чөлөөлөх зорилгоор Сайд нарын зөвлөлийн 20-р тогтоол гарч төгрөгийн худалдан авах чадвар ханш 2 дахин унаснаас улс даяар бараа товарын хомстолд орж банкны байгууллага иргэдийн гар дээр байгаа бэлэн мөнгийг татахын тулд Улсын банкнаас шийдвэр гаргаж хадгаламжийн хүүний доод хэмжээг 7%-иас доошгүй байхаар тогтоож нийлмэл аргачлал гэгчээр тооцоолход жилийн 125,1% байхаар зохицуулалт хийснээс шалтгаалж зээлийн хүү 100-160 гаруй хувь болж байсан. Үүнийг өнөөгийн эдийн засгийн нөхцөлд олгож байгаа зээлийн жилийн 20 орчим байгаа хүүтэй харьцуулж зэрэгцүүлж үзэх ямар ч үндэслэлгүй.

Ардчилсан, чөлөөт эдийн засагтай улсад зээлийн хүүнд хязгаар тогтоох нь асуудлыг шийдэх гарц биш гэж эдийн засагчид шүүмжилж байгаа?

-Зээлийн хүүнд хязгаар тогтоох нь шийдэх гарц биш гэх шүүмжлэлтэй санал нэг байна. Ер нь зээлийн хүүг төв банк юм уу арилжааны банк шийдэж буулгачихдаг зүйл биш. Учир нь, мөнгөний үнэ цэнийг төр биш, зах зээл тодорхойлох зарчим үйлчилж байгааг ойлгох хэрэгтэй. Зээлийн хүүнд хязгаар тогтоох тухай ярих бус, харин жижиг дунд

Юун түрүүнд эдийн засгийн үндсэн суурь гэгдэж буй үнэ, төгрөгийн ханш, хүүг албан хүчээр тогтоох гэсэн болчимгүй яриа байж болохгүй. Зээлийн хүү өндөр байгаа гол шалтгаан гэвэл гадаадын хөрөнгө оруулалт зогсонги байдалд орж, гаднаас орж ирэх мөнгөний урсгалд хомстол үүссэнээс мөнгө ховордож байна. Мөн бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх, тогтвортой хуулийн орчин зүй ёсоор үгүйлэгдэж байгаагийн илрэл.

үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг бууруулж, гадаадаас орж ирэх мөнгөний урсгалыг ихэсгэж мөнгөний нийлүүлэлтийг өсгөвөл эдийн засаг тэлж хувийн хэвшил дэвжсэнээр ард иргэдийн орлого, хадгаламжийн хуримтлал өсч нэмэгдэх хэмжээгээр зээлийн хүү аажмаар буурах нөхцөл бүрдэнэ. Зээлийн хүүнд дээд, доод хязгаар тогтооно гэвэл хадгаламжийн хүүний асуудал зайлшгүй хөндөгдөнө. Энэ хоёр нэг зоосны хоёр тал гэсэнтэй утга нэг шүү дээ.

Саяхан УИХ-аар Төв банкны тухай хууль батлагдсан. Энэ талаар таны байр суурь ямар байна вэ?

-Урьд нь төв банкны Ерөнхийлөгч дангаар шийдвэр гаргаж эрсдэлтэй алхам хийсэн учир одоогийн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж эрх мэдлийг хязгаарлахаар хуульд тусгагдсан нь зүйтэй гэж үзэж байна. Бодлогын чанартай шийдвэрийг мэргэжлийнхээ дагуу банк санхүүгийн байгууллагад удирдах алба хашиж байсан онолын болон мэргэжлийн чиглэлээр дадлага туршлагатай хүмүүсээр бүрдүүлсэн орон тооны бус зөвлөл хэлэлцэж, улс төрөөс ангид шийдвэр гаргах нь оновчтой гэж үзэж байна. Энэ зөвлөлийн бүрэлдэхүүнийг тодорхой шалгуурыг хангаж чадах, чадварлаг хүмүүсээр бүрдүүлж чадвал оновчтой хамтын зөв шийдвэр гаргаж чадна.

Банкны тухай шинэ хуулийн концепцийн талаар саналаа хуваалцана уу?

-Төв банкнаас арилжааны банкуудад тавих хяналт шалгалтын тогтолцоонд зарчмын томоохон өөрчлөлтүүд орсон байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалт олон улсын хэмжээнд хийгдэхгүй

болсон учир шинэчилсэн нэмэлт өөрчлөлтөөр урьдчилсан буюу эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжүүлж олон улсын жишигт нийцүүлж байгаагаараа онцлогтой байгаа юм. Ийм байдлаар хийгдсэн шалгалт нь тухайн банкинд гарсан хүндрэлийг урьдчилан тогтоож эрсдэлээс сэргийлэх бүрэн боломжийг нээн олгож, цаашид зээлжүүлэлтийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлснээр тухайн банкны үйл ажиллагааг тогтворжуулахад чиглэгдсэн сан байгуулагдана. Ер нь ямар нэгэн системийг хамарсан хямрал үүссэн тохиолдолд түүнээс хамгаалахдаа төрөөс бус энэ дундын сангаасаа дэмжлэг туслалцаа авах боломж нээгдэж байгаа гэж ойлгож байна. Энэ хуулийн нэмэлт өөрчлөлтөөр үндсэн гол нь албадлагын шинж чанар бүхий арга хэмжээний зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчимд шилжиж байгаагаараа онцлог талтай. Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг өндөрсгөсөн нэмэлт заалт нь Зохистой засаглалын зарчимд нийцүүлж Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагад тавих шаардлагыг олон улсын зарчимд нийцүүлсэн зүй ёсны шаардлага гэж ойлгож байна. ТУЗ-ийн гишүүд нь аль болох банк, санхүү, хуулийн гэх мэтчилэн банкныхаа үйл ажиллагаанд хамааралтай мэргэжлийн дагуу ажлын дадлага туршлагатай хүмүүс ажиллуулах шаардлага тавигдаж байгаа.

Төгсгөлд нь асуухад та Монголын эдийн засгийн энэ оны болон цаашдын төлөв байдлыг хэрхэн харж байна вэ?

-Эдийн засгийн хувьд энэ онд болон цаашдын төлөв байдлыг миний хувьд эерэгээр харж байгаа. 2016 оны сонгуулийн дараа байгуулагдсан шинэ Засгийн газар жил хүрэхгүй хугацаанд улс орны эдийн засаг хүнд байдалд орж, хугацаа нь тулсан гадаадын өр зээлийн дарамтад орж болзошгүй байсан учраас ОУВС-ийн дэмжлэгтэйгээр "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн. Ингэснээр улс орныхоо эдийн засгийг богино хугацаанд хүнд байдлаас гаргаж тогтворжуулснаас гадна цаашдын тогтвортой өсөлтийг хангах суурийг тавих макро эдийн засгийн цогц бодлогыг хэрэгжүүлж байна. Жишээлбэл, "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд ОУВС-аас болон донор орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт шийдэгдэж хөтөлбөрийн эхний шат амжилттай хэрэгжсэнээр 700 гаруй сая ам.долларын санхүүжилт авснаар улс орныхоо эдийн засагт тулгамдаж байсан цөөнгүй асуудлыг шийдвэрлэж чадлаа. Мөн Чингис бондын эхний төлбөрийг оны эхээр амжилттай барагдуулснаар "2018 онд бодлогын реформуудаа хэрэгжүүлж эдийн засгийн өсөлт нэмэгдэх жил байх нь" гэх өөдрөг хүлээлтийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд бий болголоо. Энэ бүхэн нь ОУВС-тай байгуулсан хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны зүгээс Засгийн газрыг дэмжин олон улсын зах зээлээс мөнгөн хөрөнгө татаж банк, санхүүгийн салбарыг тогтвортой байдлыг хангахад хамтарч ажилласны үр дүнгийн илрэл юм.

Ярилцсанд баярлалаа.

Л.Энхдэлгэр

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИ (АМ.ДОЛЛАРААР, 19/І ӨДРИЙН БАЙДЛААР)

МОНГОЛБАНКНЫ СУДАЛГАА



МОНГОЛБАНКНААС 2012-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ



Монголбанкны Мөнгөний
бодлогын газрын Мөнгөний
бодлого, төсөөллийн хэлтсийн
захирал **Н.УРГАМАЛСУВД**

Аливаа бодлогын шийдвэр гаргахын өмнө түүний эерэг болон сөрөг нөлөөллийг тооцон харьцуулж үзсэний үндсэн дээр бодлогын оновчтой сонголт хийх нь өнөөдөр олон улсад мөрдөж буй нийтлэг жишиг юм. Энэ нийтлэг жишиг нь макро эдийн засгийн бодлогуудын шийдвэр гаргах бие даасан байдал хангагдсан үед буюу улс төрийн дарамт, шахалтгүй нөхцөлд хэрэгжих нь зүйн хэрэг билээ. Ихэнх орны Төв банк мөнгөний бодлогын шийдвэр улс төрийн дарамтгүй, ил тод, бие даасан байдлаар гарахад шаардлагатай эрх зүйн зохицуулалттай байдаг. Тухайлбал, мөнгөний бодлогын шийдвэрийг мөнгөний бодлогоор нарийвчлан мэргэшсэн “Мөнгөний бодлогын зөвлөл” бие даан, хамтран гаргахаар зохицуулдаг. Энэхүү бие даасан, хамтын шийдвэрийг гаргах болсон үндэслэлээ олон нийтэд тайлбарлах, таниулах замаар нээлттэй ил тод байдлаа хадгалах, зах зээл, иргэдийн хүлээлтийг удирдах боломж бүрддэг.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойшхи хугацаанд төсвийн бодлоготой харьцуулахад мөнгөний бодлогын бие даасан байдал харьцангуй сайн, улс төрийн нөлөө багатай байсан. Гэсэн хэдий ч мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд улс төрийн дарамтаас шалтгаалан валютын ханшаа хамгаалах бодлого явуулж байсан жишээ цөөнгүй байсан. Тухайлбал, Монголбанкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй бодлогын арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэрийг Монголбанкны бодлогын зөвлөлөөс бус, улс төрийн түвшинд гарч, Монголбанкны бие даасан байдал алдагдсан талаар

эрдэмтэн, судлаачид төдийгүй олон улсын байгууллагууд онцолсон. Ийнхүү улс төрийн түвшинд мөнгөний бодлогын шийдвэр гарсан нь эдийн засагт ямар үр дагавар бий болгосон талаар нарийвчлан судалж, баримтжуулан тайлбарласан судалгаа одоогоор хийгдээгүй байна. Иймээс Монголбанкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, түүний эдийн засагт бий болгосон үр дагаврыг тодорхойлж, тэдгээрийн нийлбэр нөлөөг тооцож, тайлбарлах хэрэгцээ шаардлага байна.

2012 оны сүүлийн хагас жилээс 2016 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн мөнгөний бодлого Монголбанкны хувьд өмнө нь хэрэгжүүлж байгаагүй “цоо шинэ төрлийн бодлогын арга хэмжээнүүд”-ээр дүүрэн байв. Эдгээрт нэгд: Засгийн газраас хэрэгжүүлдэг төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 7.3 их наяд төгрөгийн эх үүсвэрийг зах зээлийн хүүнээс бага хүүгээр банкуудад нийлүүлсэн, хоёрт: ГВАН-ийн хүрэлцээтэй байдлаас үл хамааран төгрөгийн ханшийг интервенц хийж хамгаалсан, гуравт: Хятадын ардын банктай байгуулсан төгрөг/юанийн своп хэлцлийг валютын интервенцэд ашигласан зэрэг болно.


Монголбанк 2012-2016 онуудад Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр” болон бусад төсвийн шинж чанартай хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд их хэмжээний төгрөгийг эдийн засагт шинээр нийлүүлж, гадаад валютын ханшийг харьцангуй тогтвортой хадгалах бодлогыг хэрэгжүүлсэн. Энэ бодлогын арга хэмжээ нь

мөнгөний бодлогын хэрэгжилт болон Монголбанкны балансад дараах нөлөөллийг үзүүлсэн. Үүнд:

Монголбанк зах зээлийн хүүнээс бага хүүгээр банкуудад мөнгө нийлүүлж, банк хоорондын захын хүүг гажуудуулж, банкуудад хүүний арбитраж үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд Төв банк өөрөө бодлогын хүүнийхээ банк хоорондын захад үзүүлэх нөлөөллийг бууруулсан.

Хөтөлбөр хэрэгжүүлснээр мөнгөний нийлүүлэлт өсч дотоод эрэлт болон импортыг нэмэгдүүлсэн. Тухайлбал үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн санхүүжилтийн дийлэнх хэсэг импортын орц өндөртэй барилгын салбарт орон сууцны болон үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламж барих болон импортын бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, шатахуун худалдаж авахад зарцуулагдсан байна. Ийнхүү импорт нэмэгдсэнээс зах зээл дэх гадаад валютын эрэлт өсч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт нэмэгдэхэд Монголбанк төгрөгийн ханшийг харьцангуй тогтвортой байлгах зорилгоор гадаад валютын интервенцийг 7 хоногт 2 удаа тогтмол хийх болсон нь гадаад валютын цэвэр нөөц богино хугацаанд буурч, сөрөг түвшинд хүрэхэд нөлөөлсөн.

Монголбанкны дотоод актив 2013 оноос хөтөлбөрийн хөнгөлттэй зээлээр тэлж, харин үйл ажиллагааны алдагдал нэмэгдэн, өөрийн хөрөнгө буурч эхэлсэн. Тухайлбал 2016 онд алдагдлын хэмжээ огцом нэмэгдсэнээр Монголбанкны хуримтлагдсан алдагдал 3.0 их наяд төгрөгт хүрч, өөрийн хөрөнгө сөрөг утгатай болсон. Алдагдал ийнхүү хуримтлагдахад 2012-2016 онуудад Монголбанкнаас хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй үйл ажиллагаа, түүний сөрөг үр дагаврын нөлөөгөөр Монголбанкны бодит бус алдагдал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.



1а. ГВЦН ба интервенц 16.МБ-ны бодит бус алдагдал



Монголбанк мөнгө шинээр хэвлэх замаар төсвийн шинжтэй хөтөлбөр санхүүжүүлсэнээр эдийн засагт бий болсон үр дагаврыг статистик тоон мэдээлэл дээр үндэслэн дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

Хөтөлбөрийн хүрээнд импортын орц өндөр үйл ажиллагааг голчлон санхүүжүүлсэнээс импортын эрэлт нэмэгдэхэд ханшийг харьцангуй тогтвортой барих бодлогыг хэрэгжүүлсэнээс гадаад валютын нөөцийн хүрэлцээтэй байдал алдагдаж улмаар ханш сулрах дарамтыг улам эрчимжүүлсэн,

Хөтөлбөр хэрэгжүүлэх улс төрийн дарамт өндөр байснаас Монголбанк гадаад валютын албан нөөцийн хүрэлцээт байдал алдагдах үеэс нөөцийг өндөр хүүтэй дотоод, гадаад зээлээр түр хугацаанд бүрдүүлж, гадаад худалдааны шаардлагатай санхүүжилтээс гадна интервенц тогтмол хийж байсан,

Гадаад валютын цэвэр нөөц сөрөг болж богино хугацаатай гадаад өр төлбөрөө төлж чадахгүй нөхцөлд хүрснээс ханш сулрах дарамт эрчимжиж, төгрөгийн өгөөж сөрөг түвшинд хүрснээс банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд эрсдэл учруулж эхэлсэн.

Хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг зах зээлийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон нь зээлийн дахин үнэлгээнээс үүсэх бодит бус алдагдал, интервенц их хэмжээтэй тогтмол хийснээс гадаад цэвэр актив сөрөг түвшинд хүрч Монголбанкны ханшийн тэгшитгэлээс үүсэх бодит бус алдагдал, гадаад хүүний төлбөр нэмэгдсэнээс үүсэх бодит алдагдлыг тус тус нэмэгдүүлсэн. Эдгээрийн нөлөөлөл нь цаашид ч үргэлжлэн, Монголбанкны алдагдал нэмэгдэх үндсэн нөхцлийг бий болгоод байна.



2012 оны сүүлийн хагас жилээс 2016 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн мөнгөний бодлого Монголбанкны хувьд өмнө нь хэрэгжүүлж байгаагүй "цоо шинэ төрлийн бодлогын арга хэмжээнүүд"-ээр дүүрэн байв. Эдгээрт нэгд: Засгийн газраас хэрэгжүүлдэг төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 7.3 их наяд төгрөгийн эх үүсвэрийг зах зээлийн хүүнээс бага хүүгээр банкуудад нийлүүлсэн, хоёрт: ГВАН-ийн хүрэлцээтэй байдлаас үл хамааран төгрөгийн ханшийг интервенц хийж хамгаалсан, гуравт: Хятадын ардын банктai байгуулсан төгрөг/юанийн своп хэлцлийг валютын интервенцэд ашигласан зэрэг болно.

Монголбанкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээний эдийн засагт үзүүлсэн нийт нөлөөг эдгээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлээгүй байх альтернатив бодлогын сонголттой харьцуулсан нөлөөллийн шинжилгээг хийж, судаллаа. Шинжилгээний үр дүнгээр хэрэв эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээгүй бол мөнгөний нийлүүлэлт хөтөлбөр хэрэгжүүлсэн түвшнээс буурч тэр хэмжээгээр үйлдвэрлэлийн зөрүү буюу эрэлт хумигдаж, инфляци саарч, нэрлэсэн ханш сулрах эрч харьцангуй алгуур явагдах байсан байна. Инфляци харьцангуй бага, төгрөгийн ханш алгуур сулрах нөхцөл нь нэрлэсэн хүүний түвшинг бууруулах нөлөөг 2012-2013 онд үзүүлэхээр байлаа. Хөтөлбөр хэрэгжиснээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр эрэлтийг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлж, эдийн засгийн өсөлт саарах явцыг бууруулж чадаагүй байна. Хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан цөөн тооны ААН-ийн хэмжээнд үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий боловч нийлбэр нөлөөгөөрөө эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Монголбанкнаас 2012-2016 онд хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй бодлогын арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр улс төрийн түвшинд гарсан нь нэгд: Монголбанкны үйл

ажиллагааны бие даасан байдлыг алдагдуулсан, хоёрт: эдийн засагт үзүүлсэн нийлбэр нөлөө нь сөрөг байснаас макро болон санхүүгийн эрсдлийг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн хүдрэлээс МУ өөрийн дотоод эх үүсвэрээр гарах боломжгүй болоход нэмэр болсон. Тухайлбал гадаад сөрөг шокийн хэмжээ харьцангуй бага байхад их хэмжээтэй интервенц тогтмол хийх болсон шалтгаан нь төсвийн шинжтэй хөтөлбөрүүдийн импортын хэрэгцээг харьцангуй тогтвортой төгрөгийн ханшийн түвшинд хангах бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой гэж хэлж болох юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөцийн хүрэлцээтэй байдалд алдагдаж, сөрөг түвшинд хүрсэн нь улс төрийн шийдвэрээр хийгдсэн үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, түүнийг даган импорт нэмэгдэхэд, нэрлэсэн ханшийг харьцангуй тогтвортой барьсан бодлогын үр дагавар байсан. Монголбанкны бие даасан байдлыг хамгаалсан институциональ тогтолцоо сул, төв банкны хуульд Засгийн газрын урт хугацаатай үнэт цаасыг худалдан авахад хязгаар тогтоогоогүй, өр барагдуулах зорилгоор худалдах авах активыг ялгаж ангилаагүй зэрэг хуулийн дутагдалтай байдал ийм төсөвтэй адилтгах санхүүжилт хийх боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэж болох юм.

2006 ОНЫ НОБЕЛИЙН ШАГНАЛ-ИНФЛЯЦИ БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ХАМААРАЛД ХИЙСЭН ЭДМУНД ФЕЛПСИЙН НЭЭЛТ

"Монголбанкны Мэдээлэл" товхимолд эдийн засгийн салбарт хийгдсэн томоохон нээлтүүдийг тайлбарлан таниулах зорилгоор Нобелийн шагналтнуудын буланг эрхлэн гаргаж байна. Нобелийн нэрэмжит шагналыг анх 1901 онд 5 чиглэлд олгож эхэлсэн бөгөөд 1968 оноос Шведийн төв банкны санаачлаг болон хандиваар эдийн засгийн шинжлэх ухаан нэмэгдэж, салбартаа чухал нээлт хийсэн эрдэмтэн судлаач нарыг жил болгон шалгаруулж, шагнал гардуулдаг болсон. Энэ дугаарт бид 2006 онд эдийн засгийн Нобелийн шагналыг хүртсэн эрдэмтэн болох Эдмунд Фелпсийг танилцуулж түүний судалгааны ажлыг энгийн үг хэллэгтэйгээр тайлбарлаж, хүргэхийг зорилоо.

Филлипсийн муруй

Бүх зүйл Шинэ Зеландийн эдийн засагч Виллиам Филлипсээс эхэлсэн аж. Виллиам Филлипс нь макро эдийн засгийн чухал онолуудын нэг болох өөрийн нэрээр нэрлэгдсэн Филлипсийн муруйгаар алдартай. Тэрбээр академик амьдралынхаа ихэнхийг Лондоны Эдийн Засгийн сургуульд ("LSE") багшилж өнгөрөөсөн бөгөөд анх матрын анчин, кино театрын менежерээр ажиллаж, цахилгааны инженер мэргэжлээр сурч байсан ч амьдралын шуурганд туугдсаар эдийн засгийн алдарт профессор болсон.

Филлипс LSE-д сурч байхдаа үндэсний мөнгөн орлогыг тооцоолох аналог компьютерийг зохион бүтээснээр сургуульдаа багшлах эрхийг хүртсэн юм. Багшлах хугацаандаа Их Британийн ажилгүйдлийн түвшин, тоон үзүүлэлтүүдийг ихээр анхаарч, судалж байсан бөгөөд энэ нь цаашлаад цалингийн түвшинтэй эсрэг хамааралтай болохыг илрүүлэхэд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл хэрэв цалингийн хэмжээ бага байвал ажилгүйдлийн түвшин өндөр байх хандлагатай. Нөгөөтэйгүүр хэрэв цалин бага, ажилгүйдэл өндөр байвал хүн амын нийт эрэлт багсаж, инфляцийн түвшин буурдаг. Эдгээр хамаарлыг судалсан тэрбээр 1958 онд алдарт нийтлэлээ бичиж Филлипсийн



муруйг анх зурсан.



муруйд хоёр үндсэн параметрийг авч үздэг. Зурагт үзүүлсэнчлэн хэвтээ тэнхлэгт ажилгүйдлийн түвшин, босоо тэнхлэгт инфляцийн түвшин. Эдгээр нь эсрэг хамааралтай бөгөөд хэрэв ажилгүйдлийн түвшин их бол инфляцийн түвшин бага байна. Филлипс энэхүү хамаарлыг Их Британи болон бусад улс орнуудын тоон үзүүлэлтүүд дээр баталсан. Үр дүнд нь эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж байх үед инфляци, ажилгүйдлийн түвшин хоёрын зөвхөн аль нэгийг нь онилох боломжтой гэсэн дүгнэлт гарсан аж. Мөн төсвийн эсвэл мөнгөний бодлогыг тэлэх замаар нийт эрэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг буруулж болно гэжээ.

Филлипсийн муруй судлаачдын дэмжлэгийг хүртсэн ч макро эдийн засгийн маш чухал сэдвүүдийг хөндсөн учраас маргаануудыг мөн дагуулсан. Түүхээс харахад 1974 оноос хойш нийт 7 эдийн засгийн Нобелийн шагналыг Филлипсийн муруйг сөрж няцаах, засаж сайжруулах хүрээнд хийгдсэн ажлуудад олгосон. Тэдгээрийн нэг бол ойролцоо дуудлага бүхий овогтой Эдмунд Фелпс юм.

Эдмунд Фелпсийн олон ургалч үзэл

Эдмунд Фелпс нь АНУ-ын Иллинойс мужийн Эванстон хотод төрсөн боловч өөрийгөө Нью Йорк

мужийн Хэстингс хотын бүтээгдэхүүн гэж ярих дуртай. Бага ахуйдаа хөгжимд дуртай байсан нь чөлөөт сэтгэлгээг хөгжүүлсэн бөгөөд хожим нь Амхерстийн Коллежид хүмүүнлэгийн чиглэлээр сурч байх үед эдийн засгийн чиглэлээр мэргэшиж, шинийг хийж бүтээх суурь нь болсон. Ялангуяа микро болон макро эдийн засгийн онолуудыг судлах явцад хоорондох зөрүүтэй байдал нь томоохон сэдэл болж цаашид Йелийн их сургуульд докторын зэргээ хамгаалахад хүргэсэн. Тухайн үед буюу 1950-аад онд Кейнсийн онол давамгайлж байхад Йелийн их сургууль эдийн засгийн олон ургалч үзлийн төв байсан. Түүний үзэлд хичээл орж байсан Кейнсийн талын Жеймс Тобин чухал нөлөө үзүүлсэн ч мөн Австрийн талыг баримтлагч Феллнер, Маршак нар ч ихээхэн нөлөөтэй болохыг дурдсан байдаг.

Филлипсийн муруй 1960-аад онд хүчээ авсан бөгөөд бодлого тодорхойлогч, судлаач нарын дунд хэлэлцүүлгүүдийг өрнүүлж, сайшаагдаж байсан. Энэ үед Фелпс Пенсильванийн Их сургуульд профессор байсан бөгөөд хөдөлмөрийн зах, цалин, инфляцийн талаар ихээр судалж 1968 онд “Мөнгө-цалингийн динамик бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр” нэртэй алдарт нийтлэлээ бичиж Филлипсийн муруйг сөрж чадсан юм. Инфляци зөвхөн ажилгүйдлийн түвшин гэдэг параметртэй хамааралтай байгаад зогсохгүй хүлээлт гэсэн өөр нэг маш чухал параметрийг орхигдуулж болохгүйг тайлбарласан. Ийнхүү хүлээлтийг хамааруулсан Филлипсийн муруй гэгч загварыг бүтээж чадсанаар, инфляцийн хүлээлт өөрчлөгдөхөд бодит инфляци дагаж өөрчлөгддөг бөгөөд хүлээлт нь мөн ажил олгогч, ажилтнуудын цалинтай холбоотой шийдвэр гаргах үндэслэл болдгийг тайлбарласан.

Урт хугацаанд Филлипсийн муруй

Фелпсийн дэвшүүлсэн санаа эмпирик судалгаанууд дээр ихээхэн амжилт олж чадсан. Үүний гол шалтгаан нь Филлипсийн анхны муруй богино хугацаанд бодитой байж чадах ч урт хугацаанд арай өөр зурагдахыг илрүүлсэнд оршиж байв. Учир нь гэвэл урт хугацаанд эдийн засаг ажилгүйдлийн тогтвортой түвшин рүү тэмүүлж, тус муруйг босоо тэнхлэгт шулуун хэлбэртэй болгодог. Өөрөөр хэлбэл, урт хугацаанд инфляцийн түвшин өөрчлөгдөж болох ч ажилгүйдлийн түвшин харьцангуй тогтмол байна. Муруйг энэ өнцгөөс няцааж байсан өөр хүн бол монетарист эдийн засагч Милтон Фридман юм.



Улс орны эдийн засаг цаг хугацааны хувьд инфляцийн зөрүү (inflationary gap), уналтын зөрүү (recessionary gap), бүрэн ажил эрхлэлтийн аль нэгэн дээр оршиж байдаг. Инфляцийн зөрүүтэй үед инфляци өндөр, ажилгүйдэл бага байдаг бол уналтын зөрүү буюу эдийн засгийн хямралын үед инфляци буурч, ажилгүйдэл өсдөг байна. Харин бүрэн ажил эрхлэлт гэдэг нь хэвийн түвшний ажил эрхлэлтийг нэрлэдэг. Эдийн засагт ажилгүйдлийн түвшин хэзээ ч 0%-д хүрэх боломжгүй бөгөөд үргэлж завсрын болон бүтцийн шинжтэй ажилгүйдэл байсаар байдаг. Тиймээс ажилгүйдлийн хэвийн түвшинд хүрэхийг бүрэн ажил эрхлэлтэд тооцдог билээ.

Хуримтлалын алтан загвар

Фелпсийн макро эдийн засагт хувь нэмрээ оруулж, Нобелийн шагналыг хүртэх болсон өөр нэг шалтгаан нь айл өрх, цаашлаад улс орны хэрэглээ, хуримтлал хоёрын зөрчилдөөнийг тайлбарласанд оршдог. Тэрбээр хэрвээ улс орнууд хуримтлал буюу ирээдүй хойчдоо зориулж хийх капитал хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлбэл өнөөдрийн хэрэглээ, зарцуулалтаа багасгах шаардлагатай болно гэжээ. Ирээдүй хойчдоо хийх хөрөнгө оруулалт, хуримтлалын хэмжээ нь өнөөдрийн бидний хэрэглээтэй эсрэг хамааралтай аж. Энэ нь цаашлаад хүн амын үе хоорондын зөрчилдөөнийг үүсгэх эрсдэлтэй учир анхаарвал зохих салбар юм.

Эцэст нь Эдмунд Фелпс залуу эдийн засагчдад хандаж “Эдийн засагт судлаач нар хэтэрхий их статистик, эконометрик тоон үзүүлэлтүүд рүү хэлбийх тал байдаг. Би өөрөө хүртэл эдийн засгийн түүхийг орхигдуулж, хожим нь хэчнээн чухал гэдгийг ойлгосон бөгөөд эдийн засгийг нийгмийн ухаан гэдгийг мартаж болохгүй шүү” гэж хэлснээр энэхүү тоймыг өндөрлөж байна.

Н.Батжин



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ БОЛОН САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШИГ

2007-2009 оны эдийн засгийн хямралын өмнө санхүүгийн үйлчилгээ авдаг хэрэглэгчийн тоо дэлхий дээр жилд ойролцоогоор 150 саяар өсч байсан гэх судалгаа бий. Эдгээр хэрэглэгчийн ихэнх нь хөгжиж буй орны иргэд бөгөөд тус орнуудад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролын хөгжил дөнгөж анхан шатны түвшинд одоог хүртэл байсаар байна.

Зах зээлийн нийгэм рүү шилжсэн улс орнуудын хувьд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь тогтвортой болон өрсөлдөхүйц зах зээлийг бий болгоход чухал хувь нэмэр оруулдаг. Дундаж болон дунджаас доош орлоготой иргэдийн санхүүгийн мэдлэг муу, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр маш сул байдаг. Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл нэмэгдэж байна.

Хөгжиж буй оронд гэлтгүй, хөгжингүй орнуудад хүртэл хэрэглэгчдийн эрхийг зөрчих, тэднийг залилах зэрэг

асуудлууд байгаа нь иргэдийн санхүүгийн боловсролын түвшинтэй мөн холбоотой билээ. Иймээс улс орны бодлого боловсруулагчид дээрх асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахаар зорьж буй юм. Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог.

Сүүлийн 10 жилийн хугацаанд өрхийн зээл авах хэрэглэгчдийн тоо дэлхийн ихэнх оронд огцом өссөн. Жишээ нь, ОХУ-д өрхийн зээлийн хэмжээ сүүлийн 5 жилийн дотор нийт банкны зээлийн 20%-ийг эзлэх хэмжээнд хүртлээ өссөн байдаг. Өрхийн зээл, ипотекийн зээл авсан иргэдийн ихэнх нь зээлийн эрсдэл, хариуцлагаа бүрэн ухамсарлахгүй зээл авдаг ба санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд тэдэнд ойлгоход хэцүү нэр томъёо бүхий гэрээнүүдийг санал болгодог нь хэрэглэгчийн эрх

ашиг зөрчих, улмаар үл ойлголцол үүсэхэд хүргэдэг.

Дэлхийн эдийн засгийн хямралын үеэр санхүүгийн секторын системийн эрсдэлийг бууруулахын тулд иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах нь чухал гэдгийг улс орнууд онцолсон байдаг. Тухайлбал, 2000 оноос АНУ-д бага орлоготой иргэдийг (санхүүгийн мэдлэг, мэдээлэл тааруу иргэд) хувийн байшинтай болоход нь туслах хууль эрх зүйн болон урт хугацааны зээл олгон дэмжих бодлогыг өргөн хэрэгжүүлсэн. 2007-2008 онуудад бага орлоготой өрхүүд зээлээр авсан байрныхаа сарын төлбөрийг хийж чадахаа больж банкинд буцаан өгөхөд хүрсэн нь эдгээр байрны үнэ унахад хүргэсэн. Ингэснээр АНУ-д хувийн орон сууцны мөнгөн үнэлгээ 1/3-ээр унасан нь орон сууц эзэмшигчдийн хөрөнгийг даруй 6 триллион ам.доллараар багасгасан байна. Дунджаар 300 мянган ам. долларын өртөгтэй 7 сая байшингийн төлбөр эргэн төлөгдөхгүйгээс үүдэн нийт банк, цаашилбал санхүүгийн системд 2.1 триллион долларын алдагдал, мөн иргэдийн эргэн төлж чадахаа больсон зээлийн картын өр, оюутны сургалтын төлбөрийн зээл, машины зээлийн төлбөр нийлээд 10-12 триллион ам.доллар болсон нь банкны салбарт тулгарсан дийлдэшгүй их алдагдал байлаа. Бага орлоготой өрх авч буй зээлийнхээ эргэн төлөлт, эрсдэлээ тооцож зээл авсан нь эргэлзээтэй байв. Энэхүү эрсдэл нь дэлхий дахинд нөлөөгөө үзүүлсэн томоохон эдийн засгийн хямрал болсон билээ. Хямралаас хойш нийгмийн санхүүгийн системд итгэх итгэлийг эргүүлэн олж авахын тулд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн.



Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь зах зээл дээр санал болгож буй бүтээгдэхүүнийхээ талаар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байдаг бол хэрэглэгчид буюу иргэд-харилцагчид нь худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар бүрэн мэдлэг, мэдээлэл байдаггүйн улмаас уг харилцаанд оролцогч этгээдүүдийн хооронд тэнцвэргүй байдал үүсдэг байна. Жишээлбэл, иргэд банкнаас зээл авахаар очиход банкны ажилтан урьдчилан бэлтгэсэн зээлийн гэрээ үзүүлдэг бөгөөд уншихад хүндрэлтэй жижиг үсгийн фондоор бичигдсэн, ямар заалт дээр голлон анхаарах нь тодорхойгүй, цаг хугацааны хувьд тухайн үед хангалттай уншиж танилцах боломжгүй олон хуудастай байх зэрэг асуудалтай тулгардаг тул санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авагч өөрийн үүрэг, хариуцлага, эрсдэлийг тооцолгүйгээр гэрээг баталгаажуулдаг. Ингэснээр зээлийг эргүүлэн төлж барагдуулах явцад хүндрэлтэй асуудал гарч ирэхэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авагч иргэн хэнд хандах, хэрхэн шийдвэрлэх тал дээр бас л ойлгомжгүй байдал үүсдэг бол эргээд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч талд чанаргүй зээлийн хэмжээг ихэсгэж, эрсдэлийн санд илүү их хэмжээний хөрөнгө байршуулахад хүргэдэг байна.


Энэ мэтчилэн санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын харилцаанд дахь тэнцвэргүй байдлаас үүдэн гарах эдийн засаг дахь сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд хяналт, зохицуулалтын байгууллагын зүгээс санхүүгийн харилцаанд оролцогч этгээдүүдийг хариуцлагажуулах, хяналт шалгалтын стандартыг боловсронгуй болгох нь чухал байдаг.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бодлогын гол зорилго нь санхүүгийн байгууллага, хэрэглэгчийн үл ойлголцолыг арилгахад чиглэгддэг. Энэ нь хэрэглэгч талдаа санхүүгийн боловсрол олгох, санал гомдолыг шийдвэрлэх механизм, хэрэглэгчийг хамгаалсан хууль тогтоомж бий болгох; санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага талаасаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээллийг үнэн бодитоор хүргэх, хэрэглэгчид учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Х.Солонго


ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

Банк хоорондын валют арилжааны цахим талбарын арилжаагаар 2018 он гарснаар нийт 10.0 сая ам.доллар, 5.0 сая юанийн арилжаа хийгджээ. 2017 оны 4 дүгээр сарын 10 нд Банк хоорондын валют арилжааны цахим талбарыг анх нэвтрүүлснээс хойш 277.4 сая ам.доллар, 73.7 сая юанийн арилжаа буюу нийт дүнгээрээ 284.2 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний гадаад валютын 509 удаагийн арилжаа хийгдсэнийг 2016 онтой харьцуулахад 2 дахин өссөн дүн гараад байна.




МОНГОЛБАНК НЭГДҮГЭЭР САРД 1128 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2018 оны 1 дүгээр сард 1,128 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 770 кг алт авч байснаас 358 кг-аар илүү буюу 46.5%-иар өссөн үзүүлэлтэй байна. 2018 оны 1 дүгээр сарын байдлаар Лондонгийн үнэт металлын захын алтны ханш өндөр байгаагаас шалтгаалан 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 103,531.75 төгрөг байлаа. Монголбанкны алт худалдан авах үнэ өндөр байгаагаас шалтгаалан Монголбанкинд тушааж байгаа алтны хэмжээ өсөх хандлагатай байна.



Монголбанкны алт худалдан авах үнэ (төгрөг/грамм)





МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



MBA
MONGOLIAN BANKERS ASSOCIATION



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Credit Insurance Corporation of Mongolia



MONGOLIAN MORTGAGE CORPORATION
МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31